ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНЫ 12 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2020 оны 12 дугаар сарын 27 Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2020 оны 12 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Ажлын албанаас 2020 оны 12 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Аймгийн ИТХ-ын III хуралдааныг 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр, Тэргүүлэгчдийн ээлжит бус II хуралдааныг 12-р сарын 02-ны өдөр, ээлжит III хуралдааныг 12-р сарын 15-ны өдөр тус тус зохион байгуулав.

Аймгийн ИТХ-ын III Хуралдаанаар:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулсан тухай Засаг дарга Д.Мөнхбаатарын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Хороодоос хийсэн дүгнэлт, Төлөөлөгчдөөс гаргасан саналыг хэлэлцээд "Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан зорилт, үйл ажиллагаатай уялдуулан "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн төслийг 8 бүлэг 52 зорилт 263 үйл ажиллагаатай боловсруулсан байна. Хөтөлбөрийн төсөлд төр захиргааны байгууллага болон Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэдээс цахимаар авсан 789 саналд дүн шинжилгээ хийж тусгасан байгаа бөгөөд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг даван туулж, нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах, аймаг, сумыг хөгжүүлэх бодлогын асуудлыг онцгойлон анхаарч төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан эдийн засгийн салбарын бүтцийг төрөлжүүлж, өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудад нэвтрүүлэн дотоодын нийт бүтээгдэхүүнийг жилд 6-12 хувиар өсгөх зорилтыг дэвшүүлснээр аймгийн цаашдын хөгжлийг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг 5 бүсээр төрөлжүүлэн, стратегийн бүс нутаг болох, үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж "Бэлтгэн нийлүүлэгчээс үйлдвэрлэгч аймаг", Засгийн газрын "Хүнс үйлдвэрлэгч, экспортлогч улс болох" зорилтуудыг хангах түшиц аймаг болохоор эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийг оновчтой тодорхойлж аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах салбарын эзлэх хувийн жинг 18.1 хувьд хүргэхээр төлөвлөсөн байна.

Эрүүл мэнд, соёл боловсрол, хүүхэд, залуучууд, гэр бүл, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын талаар оновчтой бодлого хэрэгжүүлж, иргэн бүр эрүүл энх, эрдэм боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэн, иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэх нь бүрэн эрхийн хугацаанд нийгмийн салбарыг хөгжүүлэх үндсэн зорилт гэж үзсэн байна.

Тогтвортой, хариуцлагатай, ёс зүйтэй, чадварлаг төрийн албыг төлөвшүүлж, хүний эрхийг дээдэлсэн, цахим технологид тулгуурласан "Иргэн төв"-тэй, авлигаас ангид төрийн үйлчилгээг хөгжүүлэхээр тусгасан нь цаг үеийн шаардлагад нийцэж байгааг тэмдэглээд "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг Хуралдааны 01 дүгээр тогтоолоор батлав.

"Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тооцоо судалгааны үндсэн дээр шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлж батлах, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг аймгийн хөгжлийн жил бүрийн төлөвлөгөө, төсөвт тусган хэрэгжүүлж, улсын төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог хангах, төсөл, хөтөлбөрт хамруулах замаар хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, иргэд олон нийтийг "Ковид-19" цар тахлаас урьдчилан, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, нөөцийн бэлэн байдлыг ханган, цар тахлын үед үйл ажиллагаа нь доголдсон, түр саатсан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн ажлыг үр дүнтэй зохион байгуулж үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний

хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг даргад даалгав.

“Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Хөгжлийн түүчээ-төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан тухайн суманд хамаарах зорилт, үйл ажиллагааг тусган зохих журмын дагуу батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөлөө.

2.“Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний төсөл аймгийн Засаг даргын мэдээлэл, тус төсөлд Хурлын Хороодоос хийсэн дүгнэлт, Төлөөлөгчдөөс гаргасан саналыг хэлэлцээд “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө”-г хавсралтад зааснаар 8 бүлэг 50 зорилт 274 үйл ажиллагаа 416 шалгуур үзүүлэлттэй баталсугай.

“Аймгийн 2021 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд тусгасан зорилтуудыг хэрэгжүүлж ажиллахдаа жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, Хөгжлийн төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн 2021 оны төсөвт тусган батлуулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн дэмжлэг авч хэрэгжүүлэх, иргэд олон нийтийг “Ковид-19” цар тахлаас урьдчилан, сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж, нөөцийн бэлэн байдлыг ханган, цар тахлын үед үйл ажиллагаа нь доголдсон, түр саатсан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн, ажлыг үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

“Сумын 2021 оны хөгжлийн төлөвлөгөө”-нд “Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн болон “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний тухайн суманд хамаарах зорилт, үйл ажиллагааг тусган баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөлөө.

3. Аймгийн 2021 оны төсвийн төслийн тухай мэдээлэл түүнд Хурлын Эдийн засаг, төсөв санхүү, өмчийн бодлогын хороо, Төв аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн дүгнэлтүүдийг хэлэлцээд аймгийн 2021 оны төсвийн татварын болон татварын бус орлогын нийт дүнг 18,347,000,0 мянган төгрөгөөр, аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 7694489,4 мянган төгрөгөөр, аймгийн төсөвт улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг 48011954,1 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 779030,1 мянган төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг 9068756,5 мянган төгрөг, аймгийн төсвийн урьд оны үлдэгдэл 3500000,0 мянган төгрөг, аймгийн ОНХСангийн шилжих үлдэгдэл 600000,0 мянган төгрөг, аймгийн мал хамгаалах сангийн 2021 оны орлого, зарлагыг 150000,0 мянган төгрөгөөр тогтоож тус тус батлав.

Коронавируст халдвар /COVID-19/ -ын цар тахлын эрсдэлийг даван туулахад чиглэсэн төсвийн урсгал зардлын оновчтой хуваарилалтыг хийж, тэвчиж болох зардлыг бууруулан, төсвийн хэмнэлтийн бодлогыг тууштай хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн эрх захирагч нарт даалган, зохион байгуулалтын арга хэмжээ авах, аймгийн төсвийн сар, улирлын хуваарийг бодитой төлөвлөн, төсвийн орлого, зарлагын сарын мэдээнд дүн шинжилгээ хийж, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, оны эхнээс жигд үйл ажиллагааг ханган татварын өр төлбөр үүсгэхгүй байх нөхцөл бүрдүүлж ажиллах, татварын албаны бүртгэл мэдээллийн системийг бэхжүүлэн, цахим төлбөрийн систем, хөндлөнгийн мэдээлэл солилцоог сайжруулж, татвар төлөх, тайлагнах, түүнд хяналт тавих үйл ажиллагаанд зарцуулах хугацааг зардлыг бууруулах, аймаг, сумын Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас олгосон газар эзэмших, ашиглах эрх, тэдгээрийн нэгж, талбаруудын мэдээллийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж, цахимжуулахад онцгой анхаарч, газрын төлбөрийн орлого, урьд онуудын дутуу төлөлтийг бүрэн хураах, ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нэг бүрийн ашигласны усны хэмжээг нарийвчлан тооцож, ус ашигласны төлбөрийн орлогыг бүрэн ноогдуулан, хураан барагдуулах арга хэмжээ авах, орон нутгийн өмчийн зүйлсийг худалдах, хувьчлах талаар гарсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдпийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолуудын хэрэгжилтийг хангаж, орон нутгийн өмч худалдан борлуулсны болон өмч хувьчлалын орлогыг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцох, сумдын Хог хаягдлын хураамжийн тарифыг шинэчлэн тогтоолгож, хог хаягдлын хураамжийн орлогыг бүрэн төвлөрүүлэх, өмнөх оны татварын өр барагдуулах

ажлыг зохион байгуулж, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, төрийн албаны хүний нөөц, шилжилт хөдөлгөөний нэгдсэн санд суурилсан төрийн албан хаагчийн цалин хөлсний төлөвлөлт, санхүүжилтийн системийг аймгийн төсвийн байгууллагуудад бүрэн нэвтрүүлэх, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуультай хамт батлагдсан Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг орон нутгийн иргэдэд сурталчлан таниулах, 2021 оны сумын төсөвтэй хамт уг албан татварын хэмжээ болон хөнгөлөлтийн хэмжээг хуульд заасан хязгаарт багтаан тогтоож, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд нэн яаралтай бүртгүүлэн 2021 оны 01 сарын 1-нээс хэрэгжүүлж эхлэх, малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоож, сумын орон нутгийн хөгжлийн санд орлого төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Төсвийн тухай хуулийн 60.2.8-д заасан зориулалтын дагуу орлогыг иргэдийн саналд үндэслэн зарцуулах ажлыг зохион байгуулан хуулийн хэрэгжилтийг оны эхнээс хангаж ажиллахад онцгой анхаарах, Төв аймаг дахь Төрийн Аудитын газар, Хурлын Төлөөлөгчдөөс гаргасан аймгийн болон сумын төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал хэмнэх талаар хийсэн дүгнэлт саналыг судлан шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, бүрэн эрхийн хугацаанд аймгийн хэмжээнд төсвийн хөрөнгөөр шинээр барих, өргөтгөх, их засвар хийх барилга, байгууламж, худалдан авах тээврийн хэрэгслэлийн эрэмбэлсэн дараалыг боловсруулан дараагийн хуралдаанд өргөн мэдүүлж батлуулан мөрдлөг болгох зэрэг арга хэмжээ авч аймгийн 2021 оны төсвийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

“Малын тоо, толгойн албан татварын тухай” хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тухайн сумын малчдын амьжиргааны түвшинтэй уялдуулан татвараас чөлөөлөх малын тоо, татвар ногдуулах малын төрөл, татварын хэмжээ, онцгойлон үзэж хөнгөлөлт үзүүлэх өрхийн шалгуур /олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, өрх толгойлсон гэх мэт/ зэргийг бодит байдалд нийцсэн тооцоо судалгаанд үндэслэн оновчтой тогтоон татвар ногдуулалтыг зөв хийж, хураан барагдуулан хуульд заасны дагуу зарцуулах асуудалд анхаарч ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөлөө.

4. Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын өргөн мэдүүлсэн 2021 оныг “Хүний хөгжил-Эрүүл мэндийг дэмжих” жил болгон зарлах саналыг хэлэлцээд 2020 онд дэлхий даяар тархаж, Монгол Улсад бүртгэгдсэн “Covid 19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг дэмжих, цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуй нэгж, иргэдэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг нь тогтворжуулах шаардлагатайг тэмдэглээд Төв аймгийн хэмжээнд 2021 оныг “Хүний хөгжил-Эрүүл мэндийг дэмжих” жил болгон зарлав.

Урианы жилийн ажлын хүрээнд зохион байгуулах үйл ажиллагаанд нутгийн удирдлагын болон төрийн бүх байгууллага, аж ахуй нэгжийг идэвхийлэн оролцуулж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргад даалгалаа.

5.Иргэнд 2020 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил тогтоох тухай аймгийн Засаг дарга Ж.Батжаргалын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, уг асуудалд Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн Хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд аймгийн 27 сумын 3768 иргэнд 617.62 га газрыг сумын төв суурин газарт шинээр өмчлүүлэхээр, 663 иргэнд 54.91 га газрыг улсын чанартай авто зам дагуу өмчлүүлэхээр, одоо эзэмшиж байгаа газрыг нь нийт 1370 иргэнд 132.03 га газрыг өмчлүүлэхээр батлан хуралдааны “Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил тогтоох тухай” тогтоолыг батлав.

6.“Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө”, “Аймгийн иргэдэд 2021 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил тогтоолгох санал уламжлах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3 дугаар хуралдааны 05 дугаар тогтоол”, уг тогтоолд тусгагдсан саналыг баталсан Засгийн газрын тогтоолын дагуу иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулж тухайн сумын иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зураглалыг сумдын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулах, Монгол улсын иргэнд газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлэх талаар сургалт сурталчилгаа, мэдээллийн ажлыг оновчтой зохион байгуулж, сумдад ажиллах нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, сум, багийн Засаг дарга, газрын даамал зэрэг холбогдох хүмүүсийн ажлын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх, тухайн сумын харьяат иргэдээс олон гадны иргэд нутаг дэвсгэрт нь газар өмчилж авсан Алтанбулаг, Аргалант, Баянцогт, Сэргэлэн, Эрдэнэ, Баянчандмань сумын газар өмчилж аваагүй

иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж дүгнэлт хийх, иргэнд газар өмчлүүлж болох хуульд заасан төв суурин газрын тэг гортигийг тэлэх, цаашид өмчлүүлэх газрыг хамгаалалтад авах ажлыг зохион байгуулах, аймгийн Засаг даргаас Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдын Засаг дарга нартай байгуулах гэрээнд газар өмчлөлийн ажлыг тодорхой тусган дүгнэж байх, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6, 7 дугаар зүйлийн 7.2 болон бусад холбогдох заалтын дагуу аж ахуйн зориулалтаар аймаг, сумын төв, суурин газарт эзэмшиж байсан газраа давуу эрхээр үнээр нь өмчлөх саналыг хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Засгийн газрын тогтоолын дагуу үнийг тогтоон өмчлүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

Сумынхаа иргэдэд газар өмчлүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтийн явцад хяналт тавьж, энэ ажлын талаар холбогдох хүмүүсийн мэдээллийг сонсож, зохих үүрэг даалгавар өгч, шаардлагатай арга хэмжээ авч, үр дүнд хүргэж ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөлөө.

Хурлын Ажлын албанаас Аймгийн ИТХ-ын III хуралдаанаар батлагдаж гарсан, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”, “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай”, “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай”, “Хүний хөгжил эрүүл мэндийг дэмжих жил зарлах тухай”, “Иргэнд 2021 онд өмчлүүлэх газрын хэмжээ тухай, байршил тогтоох тухай”, “Иргэнд 2021 онд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах тухай зэрэг аймгийн ИТХ-ын III хуралдааны тогтоолуудыг tov.Khural.mn сайт, ЗДТГ-ын мэдээллийн самбар, аймгийн Иргэний танхим дахь Хурлын үйл ажиллагааг сурталчлах самбарт тус тус байршуулан 27 сумын ИТХ-д е-мэйл хаягаар хүргүүлж олон нийтэд сурталчилж мэдээлэв.

Аймгийн ИТХ-ын III хуралдааны материалуудыг албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцүүлэн эмхэтгэж аймгийн ИТХ-ын архивт байршуулав.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит бус 6-р хуралдааныг 12-р сарын 04-ний өдөр, 17-р хуралдааныг 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр “Соёмбо” танхимд хуралдууллаа.

Тэргүүлэгчдийн ээлжит бус II хуралдаанаар:-

Тэргүүлэгчдийн ээлжит бус II Хуралдаанаар ИТХ-ын III хуралдаанаар хэлэлцэх аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл, аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд Хурлын хороодоос хийсэн дүгнэлт, Аймгийн 2021 оны төсвийн төсөлд ИТХ-ын эдийн засаг, төсөв санхүү өмчийн бодлогын хорооноос хийсэн дүгнэлт, Төв аймаг дахь Төрийн Аудитын газраас хийсэн дүгнэлт, Иргэнд 2021 онд өмчлүүлэх газрын хэмжээ байршил тогтоох тухай асуудалд ИТХ-ын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтүүдийг хэлэлцээд Хурлын хуралдаанд шилжүүлэв.

Мөн тус ээлжит бус III хуралдаанаар дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт удаан хугацаагаар шилжүүлсэнтэй холбогдуулан хувиараа хөдөлмөр эрхлэгч, хувийн хэвшлийнхний үйл ажиллагаанд гарч буй хүндрэлийн талаар аймгийн Ажил олгогч эздийн холбоо болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Төв аймаг дахь салбар нэр бүхий 7 аж ахуйн нэгжийн ирүүлсэн хүсэлтийг хэлэлцээд аймгийн хэмжээнд цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан үүссэн хүндрэлийг шийдвэрлэх “Удирдлагын шуурхай баг”-ийг аймгийн ИТХ-ын даргаар ахлуулан 9 бүрэлдэхүүнтэй байгуулав.

Тэргүүлэгчдийн ээлжит бус II Хуралдаанаар 6 асуудал хэлэлцэж Хурлын Хуралдаанд 4 асуудлыг шилжүүлж 1 тогтоол батлав.

Тэргүүлэгчдийн ээлжит бус III Хуралдаанаар:

1.Аймгийн мал аж ахуйн салбарын өвөлжилтийн байдлын тухай асуудлыг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газрын “Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 19 дүгээр тогтоолд заасны дагуу аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд бэлтгэх өвс 70.7 хувь, тэжээл 86.7 хувь, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд бэлтгэх өвс 22.8 хувь, тэжээл 18.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх онуудынхаас бага байгааг онцгой анхаарч, уг нөөцийг нөхөн бүрдүүлэх боломж, бололцоог сайтар судалж, шаардлагатай арга хэмжээ авахыг сумдын шинээр томилогдсон Засаг дарга нарт үүрэг болгож хэрэгжилтийг хангуулах, Засгийн газрын шийдвэрийн дагуу улсын нөөцөөс аймагт хуваарилагдах өвс, тэжээлийг мэргэжлийн байгууллагуудын оролцоотой хийсэн

зудын эрсдэлийн үнэлгээгээр эрсдэлийн төвшин их гарсан сумдад тэргүүн ээлжид хуваарилан хүргэх ажлыг яаралтай зохион байгуулах, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс гаргасан 2021 оны 1-3 дугаар саруудын цаг агаарын урьдчилсан төлөвөөр 1 дүгээр сард аймгийн нутаг дэвсгэрийн баруун болон баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджаас хүйтэн, ахиу цастай байгаагаас үзэхэд энэ бүс нутгийн сумдад өвөлжилт хүндэрч болзошгүй тул цас нэмэгдэж байдал хүндэрсэн үед Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолоор батлагдсан "Ган, зудын байдалд үнэлгээ хийх журам"-ын дагуу аймаг, сумын төвшинд ажлын хэсэг томилон зудын үнэлгээ хийж, зудын байдлын талаар удирдах дээд байгууллага, холбогдох газруудад танилцуулж, мэдээлэх, зудад нэрвэгдсэн малчдад туслах хөдөлгөөнийг нийтийг хамруулан өрнүүлэх зэрэг шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулах, аймгийн нутаг дэвсгэрт отроор өвөлжиж байгаа малчдын талаар Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн 63 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийг хэрэгжүүлж 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл отрын малчдыг буцахыг шаардахгүй, татвар, хураамж авахгүйгээр бэлчээр ашиглуулах, тэдний малын эрүүл мэндэд тавих хяналтыг өндөржүүлж, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, туурвын замд саатуулж, хорио цээрийн хяналт тавих журам"-ыг чанд мөрдөж ажиллах, аймаг, сумдын эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, багаж хэрэгслийн хангамж, түргэн тусламжийн машинуудын бэлэн байдлыг хангаж, шаардлагатай үед нарийн мэргэжлийн эмч нарын тусламж үйлчилгээг малчдад түргэн шуурхай хүргэх нөхцөл, бололцоог бүрдүүлэх, өвөл, хаврын улиралд цас их орсон үед хаагддаг зам, дарааг байнгын нээлттэй байлгах хүн хүч, техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулан, техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, эрсдэл тохиолдсон үед шаардлагатай арга хэмжээг шуурхай авах талаар аймгийн Авто тээврийн төв, Онцгой байдлын газар зэрэг холбогдох байгууллагуудын удирдах албан тушаалтнуудыг үүрэгжүүлэх, мэргэжлийн байгууллагаас гаргасан 2021 оны өвөл, хаврын улирлын цаг агаарын урьдчилсан төлөв, сарын, тав хоногийн цаг агаарын болон хүчтэй цасан, шороон шуурга зэрэг байгаль цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг малчдад шуурхай хүргэх ажлыг оновчтой хэлбэрээр зохион байгуулахыг сум, багийн Засаг дарга, мал бүхий аж ахуйн нэгж байгууллагын дарга нарт үүрэг болгох, мал аж ахуйн салбарын өвөлжилтийн байдлын талаар тодорхой хугацаанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг даргад даалгаж хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 25 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийг өөрийн суманд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт зөвлөв.

2.Аймгийн Засаг даргын орлогчийг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцээд Г.Сурмаа, Ц.Буманбуян нарын нэрийг дэвшүүлснийг тэргүүлэгчдийн 100 хувийн саналаар дэмжиж холбогдох байгууллагаад уламжлав.

3.Төрийн дээд одон медальд уламжлах тухай асуудлыг хэлэлцээд "Хүний гавъяат эмч цол"-оор 1, "Гавъяат малчин цол"-оор 2, "Алтан гадас одон"-оор 3, "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар 2 иргэдийг шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит бус III хуралдаанаар 3 асуудал хэлэлцэж 4 тогтоол батлан хуралдааны тэмдэглэлээр 1 үүрэг өгөв.

2020 онд аймгийн ИТХ-ын XVI, XVII, XVIII, I, II, III хуралдаанаар нийт 26 асуудал хэлэлцэж 30 тогтоол, Тэргүүлэгчдийн Хуралдаан ээлжитээр 17 удаа, ээлжит бусаар-6 нийт 23 удаа хуралдаж 169 асуудал хэлэлцэж 108 тогтоол батлан, 25 хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгсөн байна.

12-р сарын 25-ны байдлаар нийт 338 албан бичиг ирснээс хяналтын картын бүртгэлтэй хариу хүргүүлэх шаардлагатай 51 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан байна.

Аймгийн ИТХ-аас дээд шатны байгууллагад болон аймгийн Засаг дарга, хэлтэс агентлагуудад 359 албан бичгийг боловсруулж аймгийн ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нараар хянуулан албажуулж хүргүүлснээс хариу ирүүлэх 30 бичгийн хариу ирж бүртгэгдсэн байна.

2020 оны 4-р улирлын байдлаар аймгийн ИТХ-ын даргад болон Ажлын албанд хандсан нийт 27 өргөдөл бүртгэгдсэнээс хуулийн хугацаанд багтаан өргөдлийн хариуг бүрэн хүргүүлж 100 хувь шийдвэрлэж ажилласан байна.

Аймгийн ИТХ-д хандаж гаргасан өргөдөл нь:-

1. Газрын асуудлын тухай асуудлаар 5 / 18.5 %

2. Мөнгөн тусламж хүссэн тухай асуудлаар 3 /11.1%

3. Түлээ нүүрсний хөнгөлөлт , дулаан хангамж түүнтэй холбоотой асуудлаар 3 /11.1 %

4. Сонгуулийн ажилтай холбоотой асуудлаар 4 /14.8%

5. Эрүүл мэндийн асуудал болон өвчний тусламж үйлчилгээ, эмнэлэгийн үйл ажиллагааны тухай тухай асуудлаар 2 /7.4 %

6. Худаг усны тухай 1 / 3.7 %

7. Ажлын албанд хандсан 7/25.9%

8. Хүнсний нөөц, амьдрах орчны тухай 2 /7.4% асуудлаар гаргасан байна.

Аймгийн ИТХ-ын Ажлын албаны мэргэжилтэнүүд 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, тайлангуудыг нэгтгэн гаргаж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын өрөөнд 2020 оны ажлын тайлангийн хамгаалалтыг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас 12-р сарын 16-ны өдөр 27 сумын ИТХ-ын дарга, Нарийн бичгийн дарга нарт Төсвийн тухай хууль болон 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн талаар сургалт хийсэн.

Сургалт, Хурлын үйл ажиллагааг аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга Ч.Жавзанпагма нээж, сумдын ИТХ-ууд нь 12 дугаар сарын 20-ны өдрөөс өмнө “Төлөөллийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд боловсруулсан төсвийн тухай хууль болон малын тоо толгойн татварын тухай хуулийн талаарх видео хичээлийг сумдын ИТХ-ын Төлөөлөгч нарт хүргэж, сургалт хийх, өндөржүүлсэн бэлэн байдлын үед сумдын ИТХ, Тэргүүлэгчдийн хуралдааныг хэрхэн зохион байгуулах, сумдын ИТХ-аас ирүүлэх тайлан мэдээ болон 2021 онд сумын ИТХ, Ажлын албанаас анхаарах ажлын талаар чиглэл, зөвлөмж өглөө.

Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн байгаа энэ цаг үед тусламж, дэмжлэг хэрэгтэй байгаа айл өрхөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын хэцүү нөхцөлд туслах хандив, тусламжийн аянд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг нэгдэж аймгийн ИТХ-ын төлөөлөгч Г.Сурмаа, Ц.Жамбалсүрэн, Г.Энхболд, Т.Баатармөнх нар нэгдэж хандив өргөлөө.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын хүнд нөхцөл байдал үүсээд буй энэ цаг үед Төв сайхан бахархал, нэрийн хуудас болсон Төв аймгийн Баяндэлгэр сумын уугуул Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Гавьяат тамирчин Э.Бадар-Ууган, Баян-Өнжүүл сумын уугуул Чингис хаан одонт, Монгол улсын болон Буриад улсын Гавьяат жүжигчин Г.Ариунбаатар болон Баянчандмань сумын уугуул, бизнесмен У.Тулгаболд нарын зүгээс аймгийн Онцгой комиссод 10 сая төгрөг, 10 мянган амны хаалт, 150 ширхэг хамгаалах хувцас хандивласан юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн ээлжит 4 дүгээр хуралдаан 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 17 цагт аймгийн ЗДТГ-ын “Соёмбо” танхимд хуралдсан.

Тус Хуралдаанаар Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Цагдаагийн газраас хийсэн ажил, “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” 16 хоногийн аяны удирдлага, зохион байгуулалт, хийж байгаа ажлын талаар хэлэлцлээ.

Гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймаг, сумдын зөвлөл, Цагдаагийн газар, Прокурорын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Хүчирхийлэлгүй гэр бүлийн төлөө хамтдаа” 1 сарын аян зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагын 750 ажилтан алба хаагч нарт Гэр бүлийн хүчирхийллийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулсан, 27 сумын Засаг дарга, Нийгмийн бодлогын мэргэжилтнүүдийг 2 удаа хамруулан “Хамтарсан баг”-ийн цахим сургалтыг Нийгмийн бодлогын хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон 175 иргэнд хууль эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгч, 128 иргэн, 11 хүүхдэд холбон зуучлах үйлчилгээ үзүүлсэн байгаа бөгөөд цаашид Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг иргэдэд тогтмол сурталчлах ажлыг сумдын хамтарсан багуудаар зохион байгуулуулах, стандартын шаардлага хангасан түр хамгаалах байртай болох, зорилтот бүлэгт чиглэсэн тусгайлсан бодлого

боловсруулах, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн үзүүлэлт өндөр байгаа сумдад тусгайлсан чиглэл өгч ажиллах шаардлагатай байгааг тэмдэглээд аймгийн Засаг дарга, холбогдох газруудад тогтоолоор үүрэг, чиглэл өгөхөөр шийдвэрлэлээ.

Мөн аймгийн хэмжээнд явагдаж байгаа “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ны сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх, цахим уралдаан зохион байгуулах талаар салбар зөвлөлийн ажлын алба, холбогдох байгууллагуудад ажлын чиглэл өгсөн байна.

2020 оны 12-р сарын 23-ны өдрөөс аймгийн ИТХ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцахаар сумдад ажиллаж байна.

Энэ сарын 12-р сарын 24-ний өдөр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн ээлжит 4 дүгээр Хуралдаан хуралдах хуваарьтай байсан хэдий ч Улсын Онцгой комисс, аймгийн Онцгой комиссоос ирүүлсэн чиглэлийн дагуу хойшлогдсон байна.

<u>Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:</u>

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн ээлжит сонгуулийн үр дүнгээр бий болсон сумын Хурал анхдугаар хуралдаанаараа сумын Засаг даргад Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу нэр дэвшүүлэн дээд шатны Засаг даргад уламжилж, нэр дэвшигчдийн хуулийн шаардлага хангасан эсэхийг судлан үзэж, холбогдох хууль хяналтын байгууллага дүгнэлт гаргасаны дагуу сумын Засаг дарга нарыг томилох, бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж буй 3 сумын Засаг дарга нарын ажлыг хүлээлцэх цахим хуралдааныг 2020.12.02-ны өдөр зохион байгуулж аймгийн Засаг даргын захирамжаар 26 сумын Засаг даргыг томилоод байна.

Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргатай аймгийн Засаг дарга байгуулсан гэрээний хэрэгжилтийг тооцож холбогдох дээд шатны байгууллагад тайланг хүргүүлж, Улс, аймгийн бодлогын баримт бичиг, дунд хугацааны төлөвлөгөөний жилийн эцсийн дүнг нэгтэн тооцож ажиллав.

Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн Хуралдаанаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, Өргөдөл, гомдлын мэдээ, Нэгдсэн төлөвлөгөө, Баг-97 төслийн 1 дүгээр үе шатны хэрэгжилтийн явц, “Хүртээмжтэй чанартай-төрийн үйлчилгээ”-ний жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг тус тус хэлэлцүүлж ажиллаа.

Аймгийн 2020 оны нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит 22 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэв. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Төлөвлөгөөний нэр	Хэрэгжүүлэх арга Хэмжээний тоо	Хэрэгжилт							
		Бүрэн хэрэгжсэн 100%	Хэрэгжих шатандаа	Хэрэгжилт хангалттүй	Хэрэг-жээгүй		Хассан арга хэмжээ	Гүйцэтгэлийн %	оноо
					хөр	з/б			
Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт	107	93	6	1		2	5	95.58	4.77
Аймгийн төвд болон сумдад хийх сургалт, семинар, зөвлөгөөний төлөвлөгөөний хэрэгжилт	46	37	2	1			6	96.75	4.84
Аймгийн төвд болон сумдад хийх нээлттэй хаалганы өдөрлөгийн төлөвлөгөөний хэрэгжилт	27	24	1	1			1	96.15	4.8
Орон нутаг, харъяа хэлтэс агентлагуудад хийгдэх хяналт-шинжилгээ үнэлгээ шалган туслах ажлын төлөвлөгөөний хэрэгжилт	20	13	6	1				87.5	4.38
Багийн иргэдийн нийтийн хуралд оролцох	8	4	2				2	90	4.5

хуваарийн хэрэгжилт									
Байнгын ажиллагаатай салбар хороо, зөвлөлийн үйл ажиллагааны мэдээлэл	11	7	4					89.09	4.45
Дүн	219	178	21	4		2	14	94.58	4.73

2020 онд иргэдээс Төв аймгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг аймгийн Засаг даргын зөвлөлийн 12 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит 23 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж аймгийн Засаг даргын албан тоотоор ЗГХЭГ-т хүргэв. Хэрэгжилтийг хүснэгтээр өссөн дүнгээр харуулбал:

№	Нэр	Нийт	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувь
			Шийдвэр-лэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Аймгийн ИТХ	27	24	3			100
2	Аймгийн ЗДТГ	617	516	64		37	94
3	Сумд	12154	11153	93	125	783	93,56
4	Харьяа агентлаг, хэлтэс	2597	2542	30	7	18	99,11
Нэгдсэн дүн		15395	14235	190	132	838	94,56

Аймгийн орон тооны бус хөгжлийн төслийн багийн 2020 оны тайланг нэгтгэхэд 8 агентлаг, 6 суманд 38 төсөл хэрэгжин нийт 2,74 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татсан байна.

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхайг 12 дугаар сарын 08, 23-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулж нийт 47 үүрэг даалгавар өгч хэрэгжилт тооцон ажиллаж байна. Уг нэгдсэн шуурхайг цахимаар зохион байгуулж цар тахалын үеийн хүний бөөгнөрөл үүсгэхгүй, эрсдэл үүсгэхгүй байхад анхаарч ажиллалаа.

Төрийн албаны стандартын хүрээнд: 1. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, 14 төрлийн судалгаа, мэдээг гаргаж 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн цахим хурлаар хэлэлцүүлэн ТАЗ-д хүргүүллээ.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд МУЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журам, аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 1-р улиралд 66.92%, 2-р улиралд 70.92%, 3-р улиралд 79.39%, 4-р улиралд 94.0%-ийн гүйцэтгэлтэй гарав.





Төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагаанд салбар зөвлөлийн чиг үүргийн дагуу зөвлөгөө өгөх, шалган туслах ажлыг нэгдсэн болон хэсэгчилсэн байдлаар 7 удаа зохион байгуулахад давхардсан тоогоор 393 байгууллага, 824 албан хаагч хамрагдаж, холбогдох зөвлөмж зааварчилгаа өгч ажиллалаа.

2020 онд улс орны хэмжээнд онцгой нөхцөл байдал үүсч МУЗГ-ын шийдвэрээр коронавируст цар тахлын хорио цээрийн дэглэмийг тогтоон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байна. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед төрийн байгууллагуудын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор 21 ажлын байранд ТАЗ-ийн 2020 оны 01 дүгээр зөвлөмжийн дагуу “түр” томилгоо хийгдсэн байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн болон ажлын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, гаргасан зөрчлийг нуун дарагдуулах бус тухай бүр хуулийн дагуу хариуцлага тооцон ажиллах чиглэлийг нийт төсөвт байгууллагуудад өгч байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар 41 байгууллагын эрх бүхий албан тушаалтан 112 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна. Үүнээс сахилгын зөрчил 14, ёс зүйн зөрчил 98 байна.

Төрийн албаны тухай хуулийн 55.3-д заасны дагуу төрийн байгууллагууд албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. 2020 онд Төв аймгийн төрийн байгууллагууд албан хаагчдынхаа ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр 9.4 тэр бум төгрөг зарцуулжээ. Судалгааг товч байдлаар танилцуулбал:

№	Байгуулла-гын тоо	Албан хаагчийн тоо	Зарцуулалтын утга	Зарцуулсан мөнгөн дүн
1	135		Ажиллах орчны тохижилт, байрны засвар, эд хогшлын шинэчлэлд	4.0 тэр бум
2	108	3608	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн урамшуулал	1.8 тэр бум
3	69	947	Цалинтай чөлөө	121.9 сая төг
Нөхөн төлбөр /Судалгаа хавсаргав/				
4	173	1827	албан томилолтын зардал /59.1.1/	253.0 сая төг
5	39	540	албан ажлын хэрэгцээнд хувийн унаа хэрэглэсний зардал /59.1.2/	94.0 сая төг
6	5	54	Тээврийн хэрэгсэл, ачаа тээшийн зардал /59.1.3/	11.8 сая төг
7	5	19	хөдөлмөрийн чадвараа түр алдсан /591.4/	2.1 сая төг
8	1	1	Бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосон /59.1.5/	346.6 мян.төг
9	4	4	Ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах бол ирэх, очих замын зардал /59.1.6/	634.7 мян.төг
10	39	517	хууль тогтоомжид заасан бусад нөхөх төлбөр	293.5 сая төг
Тусламж /Судалгаа хавсаргав/				
11	83	178	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох /60.1/	2.7 тэр бум
12	1	1	Амь нас хохирсон /60.2/	39.4 сая төг
Нэмэлт баталгаа /Судалгаа хавсаргав/				
13	8	25	Орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх /61.1.5/	5.8 сая төг
14	14	55	Төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах хугацаанд албан тушаалын цалинг авах /61.1.7/	119.3 сая төг
15	8	13	Ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид 1.5 сарын цалинтай тэнцэх урамшуулал /61.1.9/	15.5 сая төг

ТАЗ-ийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаанд иргэд, төрийн албан хаагчдаар үнэлгээ дүгнэлт өгүүлж, цаашид хэрэгжүүлэх ажил үйлчилгээнд тэдгээрийн санал хүсэлтийг тусгах зорилгоор цахим санал асуулга явуулаа. Санал асуулгад оролцогчдын үнэлгээ, дүгнэлтээс танилцуулбал:

Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн үйл ажиллагаа, сул орон тооны мэдээ мэдээллийн ил тод байдлын үнэлгээ. /Нийт 91/



	Маш сайн	Хангалттай	Дунд	Хангалтгүй	Маш хангалтгүй
Хувь	28.6	50.5	18.7	2.2	0
Too	26	46	17	2	0

Төв аймагт Ерөнхий шалгалт өгсөн бол “Шалгалтын зохион байгуулалтыг хэрхэн үнэлэх вэ?” гэсэн асуултад нийт 78 үнэлгээ өгсөн байна.



Төв аймагт Тусгай шалгалт өгсөн бол “Шалгалтын зохион байгуулалтыг хэрхэн үнэлэх вэ?” гэсэн асуултад 33 хүн үнэлгээ өгсөн байна.



	Маш сайн	Сайн	Дунд	Хангалтгүй	Маш хангалтгүй
Too	17	15	1	0	0
Хувь	51.5	45.5	3	0	0

Төрийн албаны тухай хууль тогтоомж таны харьяалах орон нутагт хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэх асуултад 86 иргэн хариул өгсөн байна.



Аймаг, сумдын ЗДТГ-ын дарга нарын судалгааг гарган ТАЗ-д хүргүүлсэн.

Тайлант онд салбар зөвлөлд ирсэн хариутай бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг танилцуулбал:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэр-лэсэн	Хүлээг-дэж буй	Шийдвэр-лэлтийн хувь
1	Албан бичиг	165	111	105	6	94.59%
2	Өргөдөл, гомдол	8		8		100%

Салбар зөвлөлөөс 2020 онд 129 албан бичиг гадагш явуулснаас хариутай 71 бичиг байна. Үүнээс 45 хугацаандаа шийдвэрлэгдэж 26 нь хугацаа болоогүй хүлээгдэж байна.

2. Сургалт, мэдээллийн чиглэлээр:

Мерит төсөл хэрэгжиж буй 4 аймгийн ТАЗСЗ-ийн НБД, ХН-ийн мэргэжилтний “Туршлага судлах цахим уулзалт”-д оролцов.

3. Сонгон шалгаруулалтын чиглэлээр:

Тайлант онд ТАЗ-ийн Төв аймаг дахь салбар зөвлөлөөс 188 сул ажлын байранд 10 удаагийн тусгай шалгалт зохион байгуулж, 83 ажлын байрыг нөхөн хангалаа. /Сонгон шалгаруулалтын дүнг хавсаргав/.
Эдгээр сонгон шалгаруулалтыг төрлөөр нь авч үзвэл:



Төрийн үйлчилгээний нэгдсэн төв:

2020 оны 12 дугаар сард Төрийн болон бизнесийн дэмжих үйлчилгээний нийт 20 байгууллага 300-аад төрлийн үйлчилгээг **4782** иргэнд, өдөрт дунджаар 200-250 иргэнд хүргэж байна. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээ, арга хэмжээний мэдээллийг “Өлзий”, TBS, Төв, Сүлд, Live телевизүүдтэй, контент хуваах хэлбэрээр ТВ5, ТВ9 телевизүүдтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Мөн Аймгийн албан ёсны веб сайт, пейж хуудас, мэдээллийн болон урсдаг самбар зэрэг эх сурвалжаар иргэд, олон нийтэд түгээж байгаа 12 дугаар сард аймгийн веб сайтад **27,** “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд **69** мэдээ мэдээлэл тус тус нийтлэгдлээ. Харин 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн **2-н** дугаарыг бэлтгэн иргэд олон нийтэд хүргэсэн. Мөн бусад 7 төрлийн телевизүүдийн мэдээний цагаар **97** мэдээ мэдээлэл цацагдсан байна. Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **8** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжлан шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Одоогийн байдлаар хугацаа болоогүй **5** гомдол байна.

Мөн тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны E-mongolia цахим системийг нэвтрүүлж 9 байгууллагын 54 төрлийн лавлагаа мэдээллээр

иргэдэд үйлчилж байгаа бөгөөд 12 сард аймгийн хэмжээнд **1169** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ТҮНТөвийн операторуудаас **256** лавлагаа үйлчилгээ авчээ.

<u>Мэргэжлийн хяналтын чиглэлээр:</u>

Тус газар нь 2020 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөө, ЗДҮАМХ, ИТХ-ын тогтоол болон ИТХТ-ийн тогтоол, аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, тогтоол шийдвэр, Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнаж, аймгийн Засаг даргын харьяа агентлагуудыг үнэлсэн үнэлгээгээр 94,67% буюу "А" үнэлэгдсэн.

Мэргэжлийн хяналтын газрын даргын "Өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарь батлах тухай" 2020 оны А/45 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Шуурхай штаб болон авто замын шалган нэвтрүүлэх постод 24 цагаар хариуцлагатай жижүүрийн үүргийг албан хаагчид ээлжлэн гүйцэтгэж, мэдээ мэдээллийг холбогдох газарт шуурхай хүргэн хяналт тавин ажиллаж байна. Авто тээврийн шалган нэвтрүүлэх постод ажиллаж буй албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж явуулын постын асуудлыг шийдвэрлэсэн. Бүх албан хаагчид өвлийн хувцас захиалж, өвлийн гутлаар 100% хангасан.

Төлөвлөгөөт бус шалгалт:

Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр:

МХГ-ын даргын баталсан 19/154 дугаартай удирдамжийн дагуу Эрдэнэ, Баяндэлгэр, Мөнгөнморьт, Архуст, Баяндэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүдийн тусгаарлах байр, Өвөржанчивлан рашаан сувилал, Аржанчивлан рашаан сувиллуудын тусгаарлан ажиглах байруудын бэлэн байдлыг шалгаж,мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч,улсын байцаагчийн 51заалттай 6 зөвлөмж өгсөн. Мөн 2 ундны усны дээж авч, АМХГ-ын харьяа Итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнгийн тухай улсын байцаагчийн 1 дүгнэлт гаргасан. Баруун-Зуунмод өрхийн эрүүл мэндийн бэлэн байдлыг шалгасан.Зуунмод сумын Автотээврийн төв, таксины үйл ажиллагаа явуулдаг 3 аж ахуйн нэгжийн Коронавирусын халдварын үеийн халдвар хамгааллын дэглэм, халдваргүйжүүлэлтийн байдалд автотээврийн хяналтын улсын байцаагчидтай шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

МХЕГ-ын даргын 2020 оны А/146 дугаартай тушаалын хэрэгжилтийг 2 удаа, тоон мэдээг өдөр бүр гарган МХЕГ-т хүргүүлсэн.

Эрүүл мэндийн газрын дэргэдэх тусгай зөвшөөрлийн комиссоос ирүүлсэн хүсэлтийн дагуу Мөнгөнморьт сумын Булаг 3 дугаар багийн Хэрлэн 6 дугаар оршин суугч иргэн С.Энхтүвшины үүсгэн байгуулсан Оюут Ян ХХК-ийн эмийн сангийн байрны эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, улсын байцаагчийн хамтарсан дүгнэлт гаргасан.

Аймгийн Онцгой комиссын даргаас өгсөн үүргийн дагуу Аймаг, сум орон нутагт Коронавирусын /Ковид-19/ халдварын батлагдсан болон сэжигтэй тохиолдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Онцгой байдлын газрын болон Эрүүл мэндийн газрын холбогдох албан тушаалтнуудтай хамтран боловсруулсан.

Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2020 оны 01/249 дүгээр удирдамж, тус газрын даргын баталсан 2020 оны 19/159 дүгээр удирдамжийн дагуу Коронавируст халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг үнэлж, аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыад 29 эрүүл мэндийн байгууллагыг хамруулан гүйцэтгэж танилцуулгыг нэгтгэн МХЕГ-ын ЭМБСХГазарт 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хүргүүлсэн. Коронавируст халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын мэдээг цаг хугацаанд нь ирүүлээгүй эрүүл мэндийн байгууллагуудын тухай 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 530 тоот албан бичгийг Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.

Ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын чиглэлээр:

Зуунмод сумын нутаг дэвсгэрт төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний худалдаа эрхлэгч лангуу түрээслэгч 8 иргэний үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийхэд 4 зөрчил илэрсэн. Зөрчлийг арилгуулахаар 14 заалт бүхий улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн. Хүнсний худалдаа эрхлэгчийн бүртгэлд 1 сумын 1 аж ахуй нэгж, 2 иргэн бүртгэж код олгосон. Ургамал хамгааллын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд санал өгсөн. Атрын шим ХХК 3 төрлийн хүнсний ногооноос дээж авч шинжилгээнд хамруулсан.

Эм био бэлдмэлийн хяналтын чиглэлээр:

Зуунмод сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Түвшинсайхан энэрэл ХХК, Болд трейд ХХК, Төв эм ХХК-ийн эмийн сангуудад эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөд хяналт шалгалт хийхэд тус эмийн сангууд эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийг үйл ажиллагаандаа тогтмол мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгаль орчны хяналтын чиглэлээр Төв аймгийн Эрдэнэ сумын Баянтуул 3 дугаар багийн нутаг “Асралт хайрхан” гэх газарт ЭБЭЭ ХХК нь гэрээнд заасан хугацаанд мод бэлтгээгүй, хугацаа хэтрүүлсэн гэх зөрчлийн 2034000693 дугаартай зөрчлийн хэрэгт 2020 оны 12 дугаар сарын 15-ний өдөр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт заасны дагуу 10000 нэгжийн шийтгэл оногдуулан, зөрчлийн үр дагаврыг арилгуулах талаар эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлэн ажилласан. Мөн Төв аймгийн Прокурорын газрын 2020 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн 54 дугаартай “Зөрчлийн хэрэгт ажиллагаа хийлгүүлэх тухай даалгаврын дагуу Баяндэлгэр сумын Галуут 2-р багийн нутаг “Гэдэс хагардаг” гэх газар аюултай хог хаягдал хадгалах журам зөрчсөн Баяндэлгэр хүнс ХХК-д холбогдох 2034000733 дугаартай зөрчлийн хэргийн газарт шалгалтын ажиллагаа явуулж Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.11 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан Зөрчлийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгох тогтоол үйлдэн зөрчлийн хэргийн материалыг прокурорт хянуулахаар хүргүүлсэн.

Бусад ажил: Мэргэжлийн хяналтын байгууллагын “Гамшгаас хамгаалах мэргэжлийн хяналтын болон цацрагийн хяналтын улсын албаны төлөвлөгөө”, МХЕГ-ын даргын баталсан “Короновируст халдвартай тэмцэх сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”, Аймгийн засаг даргын 2020 оны А/593, А/605 тоот Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн үед авах арга хэмжээний тухай захирамжийн хэрэгжилтийг хангуулахаар хүнсний худалдааны давхардсан тоогоор 329, хоол үйлдвэрлэлийн 10, томоохон худалдааны төв, зах 12, эмийн сан 6, махны лангуу 20, төмс хүнсний ногооны дэлгүүр 6, нийт 97 обьектод хяналт тавьж ажилласан байна. Шалгалтаар 48% нь үйлчлүүлэгч ажилчдын биеийн халууныг үзэж бүртгэл хөтлөөгүй, 39% нь үйлчлүүлэгчдийн хүн хоорондын зай барьж үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлээгүй, 55% нь үйлчлүүлэгчид чөлөөтэй үйлчлүүлэх эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн өрөө гар угаах нөхцөл бүрдүүлээгүй, 82.4% нь QR код байршуулж бүртгэл хөтлөөгүй зөрчлүүд илэрсэн тул улсын байцаагчдын албан шаардлага 5, зөвлөмж 3-ыг хүргүүлэн ажиллалаа.

Сорилтын нэгдсэн лаборатори нь өнгөрсөн 1 сарын хугацаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 23 дээжийг хүлээн авч 101 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг хийж, шинжилгээний хариуг хугацаанд нь гарган ажилласан.

Эрүүл ахуй нян судлалын лаборатори нь нийт 20 дээжинд 71 үзүүлэлт (гурил гурилан бүтээгдэхүүний 1 сорьцонд 6, махан бүтээгдэхүүний 2 сорьцонд 10, хоолны 2 сорьцонд 10, ундны усны 15 сорьцонд 45) үзүүлэлтээр эрүүл ахуй нян судлалын шинжилгээг хийсэн ба стандартын шаардлага хангаагүй дээж илрээгүй болно.

Эрүүл ахуй хими, хор судлалын лаборатори нь нийт ундны усны 3 дээжинд 30 үзүүлэлтээр химийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн бөгөөд стандартын шаардлага хангаагүй дээж илрээгүй.

<u>Онцгой байдлын газрын хүрээнд:</u>

Д/д	Огноо Цаг минут	Мэдээ өгсөн хүний нэр, утасны дугаар	Мэдээний агуулга /Байршил/	Хүн хүч техник хэрэгсэл	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
Хөдөө орон нутгийн /Объектын галын бүртгэл/					
1	2020.12.20 09:40 цагт	БОУХБайцаагч Ш.Гэрэлт-Од 99815599	Эрдэнэ сумын Өгөөмөр багийн "Харзтай суурь" /Сумын төвөөс баруун зүгт 26 км-т/ Дөрвөн улирал амралтын газрын 8*16 харьцаатай 2 давхар дүнзэн байшин бүрэн шатман тухай мэдээг хүлээн авсан.	Налайх дүүргийн ОБХ-н ГТУА 28-р ангийн салааны захирагчийг түр орлон гүйцэтгэгч а/а Д.Сундуйгаар ахлуулсан 12 алба хаагч, 3 автомашинтай ажилласан.	13:45 цагт бүрэн унтраасан тухай мэдээг өгсөн
2	2020.12.2	Засаг дарга	Баян-Өнжүүл сумын Бараат 1-р багийн нутаг "Модод 2 дугаар	Тус сумын хэсгийн	21:55 цагт бүрэн унтраасан. /Уг

	1 22:00 цагт	Э.Наранцогт 99018424	гудамжны 1 тоотод" Ц.Дондормаагийн 5*8 харьцаатай өвлийн байшин бүрэн шатсан тухай мэдээ хүлээн авсан.	төлөөлөгч Л.Мөнх-Эрдэнээр ахлуулсан 60 хүн, 22 автомашинтай ажилласан.	айлын нь эзэнгүй байсан тухай мэдээг өгсөн.
3	2020.12.29	Иргэн Н.Энхтүвшин 99761014	Барнуур сумын Нарст багийн "Тайст" гэдэг газарт /Сумын төвөөс хойд зүгт 12 км-т/ хин-700 загварын 67-51 УНТ улсын дугаартай автомашин шатсан.	Тус сумын хэсгийн төлөөлөгч Г.Ган-Эрдэнээр ахлуусан 2 хүн, 1 автомашинтай ажилласан.	22:44 цагт бүрэн унтраасан.
4	2020.12.30 15:50	Салааны захирагч д/ч Б.Бямбаням	Батсүмбэр сумын Мандал багийн "Уйлантын ам" гэдэг газарт /Сумын төвөөс баруун зүгт 3 км-т/ 14:00 цагийн орчим машинаа галлаж асаах гэж байгаад гал алдаж 4*5 харьцаатай өвөлжөө, 2*3 харьцаатай амбаар, ланд грузер прадо-95 загварын 087-79 УНА улсан дугаартай автомашин шатсан тухай мэдээлэл өгсөн.	5 иргэн ажиллаж бүрэн унтраасан.	-
5	2021.04.04 16:25	Засаг даргын тамгийн газрын дарга А.Пүрэвсүрэн 99990845	Эрдэнэ сумын Баянтуул багийн Шивэртий гэдэг газарт /Сумын төвөөс хойд зүгт 80 км-т иргэн Д.Ганхуягийн 5 ханатай гэр эд хогшилийн хамт бүрэн шатсан тухай мэдээлэл өгсөн	-	-

<u>Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:</u>

***Удирдлага зохион байгуулалтын хүрээнд*:**

Хууль зүй, дотоод хэргийн яам, Хайнс Зайдалын сантай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын буланд 4 дугаарыг шинэ хуулиудийн сэдвээр, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 12 сарын дугаарыг “Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөө” сэдвээр бэлтгэн нийтэд хүргэлээ.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 35 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж өгч, хууль, эрх зүйн асуудлаар нийт 52 иргэн болон сумд, байгууллагуудад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа, эрх зүйн туслалцаа үзүүлж, Дотоод удирдлагын системээр шинэ хууль тогтоомжийн 19 мэдээлэл оруулж, төрийн албан хаагчдыг хууль, эрх зүйн мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.

Аймгийн Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж 1 иргэний хэргийн талаар тайлбар дүгнэлт гаргасан.

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн төслийн онлайн хэлэлцүүлэгт аймгийн удирдлагуудтай оролцож, саналаа нэгтгэн өгсөн.

“Авлигын эсрэг олон улсын өдөр”-ийг тохиолдуулан **“**Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяныг 11 дүгээр сарын 20-ноос 14 хоногийн хугацаанд цахим орчноор дамжуулан 27 сум, 22 байгууллага, tov.gov.mn албан ёсны вэб сайт, пэйж хуудсаар 17 сурталчилгааны шторк, 6 төрлийн зурагт хуудсыг байршуулж, давхардсан тоогоор 70.771 иргэнд сурталчилж ажиллалаа. Мөн аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/617 тоот захирамжаар хүүхэд залуучуудын дунд “Авлига бидний ирээдүй биш” зохион бичлэг, иргэд, төрийн албан хаагчдын дунд “Шударга

ёс” видео бичлэгийн уралдааныг 12 дугаар сарын 18-наас 12 дугаар сарын 25-ны хооронд цахимаар зохион байгууллаа.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын хэрэгжилтийг хангаж Төв аймагт үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан, мэдээ, үүрэг чиглэлийн хэрэгжилтийг гаргаж Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлд хүргүүллээ.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Төв аймгаас авч хэрэгжүүлж буй ажлын тайлан, мэдээг 12 байгууллага, 27 сумаас авч нэгтгэн 7 хоног бүр Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлд өгч ажиллалаа.

Хууль, эрх зүйн салбарын хүрээнд хамааралтай Засгийн газар, УИХ-ын тогтоол шийдвэр, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээ, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт, “Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих хөтөлбөр” “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2017-2020 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүллээ.

Архивын тасгийн чиглэлээр:

Архивын тасгаас төрийн архивын эх баримтаас үйлчилгээ үзүүлэх зорилгоор энэ сард 136 иргэний хүсэлтийг хүлээн авч 599 хуулбар хувь, 194 лавлагаа, 160 хөмрөгийн 767 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлж, орон нутгийн төсөвт 815.0 төгрөг орууллаа.

2 хөмрөгийн 89 хадгаламжийн нэгжийн 4713 хуудас баримтын 19325 хүний нэр, 3210 заалтын тоо, 3210 тушаалын тоог мэдээллийг программ хадгаламжийн нэгжийн түвшинд шивэж, 2 хөмрөгийн 89 хадгаламжийн нэгжийн 4713 хуудас баримт скайнердаж 2 хөмрөгийн 89 хадгаламжийн нэгжийн 3210 заалтыг PDF.JPEG хэлбэрт хувиргаж, 3210 заалтын 4713 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 57917 хувийн хэрэг байгаагаас Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн10441, Газар өмчлөх эрхийн 47476 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 24555.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 175.0 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 181.5 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 5.4 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 932 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 766 нэмэлт өөрчлөлт, шинээр 166 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 5, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 35 бүртгэл хийлээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 11 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 11 лавлагаа өгч, орон нутгийн төсөвт 45.3 сая төгрөгийг орууллаа.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлээр:

Аймгийн хэмжээнд 11 дүгээр сарын байдлаар нийт 731 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оноос 15,4 хувиар буурсан. Гэмт хэргийн илрүүлэлт 62,5 хувьтай, өмнөх оноос 9,5 хувиар өссөн.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байранд нийт 39 иргэнийг эрүүлжүүлж, эрүүл мэндийн үзлэгт хамруулж, ар гэрт хүлээлгэж өглөө

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, арга хэмжээний хүрээнд 26 сумын 49 постод 49 албан хаагч, үндсэн 3 пост, хөдөлгөөнтөөр 2 чиглэлд нийт 4 албан хаагч 6 цагаар,

Зуунмод суманд 4 хяналтын цэгт 2 ээлжээр 6 цагаар 12 албан хаагч, нийт 30 өдөр 720 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж, замын хөдөлгөөн, нийгмийн хэв журамд хяналт тавьж ажиллалаа.

Шүүх хурлын 1,2,3-р танхимуудад 552 оролцогчтой Эрүүгийн хэргийн 75, Иргэний хэргийн 21, Захиргааны 3, нийт 99 шүүх хуралдаанд хэв журам сахиуллаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 21 жолоочийг илрүүлж, 18 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 2 иргэнийг Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэж ажилласан. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 253 жолоочийг 2.2 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 21 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатууллаа.

Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны чиглэлээр:

Энэ сард Криминалистикийн шинжилгээ-178, Нийт хийсэн магадлан шинжилгээ-187, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-458, гарын мөрийн санг баяжуулсан-615, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 825 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Хувь
12-р сар	321	354	47	628	383	245	**61.0%**
	4335531,9	3856806,7	1408178,9	6784159,7	2161911,0	4622248,7	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд:

Нэг. Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр

1.1 Хөрөнгө оруулалт: 2020 онд аймгийн хэмжээнд улс, орон нутаг, төсөл хөтөлбөр, хувийн 81.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 цэцэрлэг, 5 сургууль, 5 дотуур байр, 4 Эрүүл мэндийн төв, 4 соёл спортын төв болон 1 төрийн захиргааны барилга нийт 21 объект шинээр барьж, 15 барилгад их засварын ажил хийгдэж, 6 чиглэлийн 19.4 км автозам шинээр ашиглалтад орлоо.

1.2. Худалдан авах ажиллагааны талаар зохион явуулсан ажил: Аймгийн 2020 оны төсөвт тодотгол хийгдсэнтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт ажил төлөвлөгдөж 2020 онд нийт 40,814.2 сая төгрөгийн 126 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 37,785.8 сая төгрөгийн 97 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж хэрэгжүүлэхээс *(дэлхий нийтэд короновурис тархсантай холбогдуулан төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн яам, бусад шалтгаанаар төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч байгууллагын албан мэдэгдэл, шийдвэрээр 3,180.1 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээний тендерийг зогсоосон)* тайлант оны 12 дугаар сарын гүйцэтгэл, өссөн дүнгээр 85 төсөл, арга хэмжээнд үнэлгээний хороог байгуулж, цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулж, худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 98%-тай байна.

Хоёр. Барилга, хот байгуулалтын чиглэлээр

2.1. Нийтийн аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд: “Нийтийн аж ауйн талаар аймгаас баримтлах бодлого 2017-2024" бодлогын хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2020.12.18-ны хуралдаанаар хэлэлцүүлэн, 75 хувьтай дүгнэгдсэн.

2.2. Барилга захиалагч, хяналтын чиглэлээр: 2020 онд Төв аймагт эрх шилжин хэрэгжих ажил захиалагчаар ажиллан, нийт 14 барилга байгууламж, тохижилтын 3551.5 сая төгрөгийн

хөрөнгө оруулалтын ажилд хяналт тавьж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7 барилга байгууламж, их засвар 2006.0 сая төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 7 барилга байгууламж, их засвар, тохижилтын ажлын 1545.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажилд захиалагчаар ажилласан.

2.3. Ерөнхий архитекторын үйл ажиллагааны хүрээнд: 2020 онд 73 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан батлаж, зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, магадлал хийх дүрмийн дагуу 49 зураг төсөл зөвшөөрөлцсөн. Засгийн газрын 2018 оны 68, 171 тоот тогтоолын хүрээнд 105 барилга байгууламжийн эхлүүлэх зөвшөөрөл олгож, "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн хүрээнд 9 барилга байгууламжид комисс ажиллан үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулаа.

2.4. Хот байгуулалтын кадастрын чиглэлээр: Хот байгуулатын кадастрын мэдээллийн санд инженерийн шугам сүлжээний цэвэр усан хангамжийн төв магистрал шугамыг бүртгэн оруулж байна.

2.5. Нөхөн бүрдүүлэлтийн хүрээнд: Аймгийн төвийн барилга байгууламж, ногоон байгууламж, зам талбайн жилийн эцсийн байдлаар 501 барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний 463 мэдээллийг бүрдүүлэн хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэлээ.

Гурав. Газрын харилцааны чиглэлээр

3.1. Газрын төлбөр: 2020 оны 12 дугаар сарын байдлаар газрын төлбөрийн орлого 3022.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 3643.5 сая төгрөгийг төвлөрүүлж 120.5%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 298.4 мянган төгрөг дутуу төлөлтөөс, дуудлага худалдаагаар 840.9 сая төгрөгийг аймаг, сумын төсөвт төвлөрүүлсэн. Аймгийн хэмжээнд 2020 онд зохион байгуулагдсан 18 сумын 330 газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааны мэдээ тайланг гаргасан.

3.2. Газар зохион байгуулалтын чиглэлээр: Аймгийн хэмжээнд нийт 5801 иргэнд 804.56 га газар өмчлүүлэхээр төлөвлөн аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 3 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн 05 дугаар тогтоолоор батлуулан ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.

Дөрөв. Орон нутгийн өмчийн чиглэлээр

4.1. Өмчийн хүрээнд: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2019 оны 77, 2020 оны 83, 09 тоот тогтоолоор дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэгдсэн автомашины дуудлагын худалдааг зарлан явуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн 4 сумын 7 төсөвт байгууллагын элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэгдэл өртөггүй болсон ч ашиглаж байгаа хөрөнгийн ашиглах жилийг сунгаж, үнийг шинэчлэн тогтоохоор ирүүлсэн саналыг судлан үзэж, тухайн байгууллагуудын саналаар үнэ, ашиглах жилийг баталсан.

4.2. Түрээсийн орон сууцны хүрээнд: Аймгийн "Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам"-ын хүрээнд 2018 онд түрээсийн 12 өрх, 2019 онд 13 өрх нийт 25 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулснаар сарын төлбөрийг график хугацааны төлөлттөнд хяналт тавьж ажилласнаар 2019 оны 19,078,000, 2020 оны 43,000,000 төгрөг буюу нийт 62,000,000 төгрөгийг төвлөрүүлсэн байна. Мөн 2020 онд Түрээсийн орон сууцанд хамрагдахыг хүссэн 130 иргэдийн өргөдлийг бүртгэлээ.

Тав. Зам харилцааны чиглэлээр

5.1. Авто замын салбарын хүрээнд: 6 чиглэлд 19.4 км автокам шинээр ашиглалтад орж, Манзушир чиглэлийн 7 км авто замын барилгын ажлыг эхлүүллээ.

Зургаа. Хөдөө аж ахуйн чиглэлээр

5.1. **Мал аж ахуйн хүрээнд:** Аймгийн хэмжээнд 2020-2021 оны өвөл, хаварт 5.1 сая буюу хонин толгойд шилжүүлсэнээр 8.7 сая толгой мал өвөлжиж, хаваржина. Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд өвс 600 тн, тэжээл 150 тн бэлтгэхээс өвс 424 тн буюу 70 хувь, тэжээл 130 тн

буюу 86.6 хувьтай нөөцөлж бэлтгэлээ. Хөдөө аж ахуйн өвөлжилтийн байдалд Зудын эрсдлийн үнэлгээ хийх 5 ажлын хэсэг 26 сумдад ажиллалаа. Зудын эрсдлийн үнэлгээгээр 14 сум зудын эрсдлийн түвшин их, 13 сум эрсдлийн түвшин дунд зэрэглэлтэй дүгнэгдэж Засаг даргын нөөц хөрөнгөөс 102.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажиллалаа. 2020 оны жилийн эцсийн малын хяналтын тооллогыг Баянжаргалан, Баянцагаан, Сэргэлэн, Лүн, Угтаалцайдам, Цээл сумдад зохион байгуулж, түүвэр хяналтын тооллогын 26 өрхийг хамруулаа.

5.2. Мал эмнэлгийн үйлчилгээний хүрээнд: Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1805.6 мян/мал хамруулж, 41273 гэрчилгээ олгож, мал эмнэлгийн 2120 дуудлага үйлчилгээ үзүүллээ. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын үйлчилгээний 78.9 сая төгрөгийн санхүүжилт олголоо.

Лүн суман дахь мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг 4 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, нийт 798 тээврийн хэрэгсэл, 6797 толгой мал, 2190.6 тн мах, махан бүтээгдэхүүн, арьс шир 100916 ширхэг, ноос 85 тн, дайвар 247.4 тн, цагаан идээ 117.5 тн бүтээгдэхүүний эрүүл ахуй, мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт хийж, зөрчилтэй 21 тээврийн хэрэгсэл илрүүлж, тухай бүр нь арга хэмжээ авч ажилласан.

5.3. Газар тариалангийн хүрээнд: 2020 онд үр тариа 67.9 мянган тонн, төмс 152.2 мянган тонн, хүнсний ногоо 21.7 мянган тонн, малын тэжээл 89.9 мянган тонныг хураан авч улсын хэмжээнд хураан авсан үр тарианы 17.0 хувь, төмсний 63.0 хувь, хүнсний ногооны 18 хувь, малын тэжээлийн 53 хувийг тус тус үйлдвэрлэж, хураан авсан ТӨМС, ТЭЖЭЭЛИЙН УРГАЦААР УЛСДАА ТЭРГҮҮЛСЭН АМЖИЛТ-аа бататгалаа.

“Аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого”-ын 2017-2020 оны хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөл, Иргэдийн Төлөөлөгчдын хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж 88.7 хувиар дүгнэгдлээ.

Газар тариалангийн салбарт хөрсний үржил шим нэмэгдүүлэх техник, үр, усалгааны техник, төхөөрөмжийн шинэчлэл болон хашаажуулалт, хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэх чиглэлээр улс болон хувийн хөрөнгөөр нийт 13.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.

Мөн “Жимс, жимсгэнэ үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 94.0 хувиар дүгнэгдэж жимс, жимсгэнэ тариалсан талбайн хэмжээ өссөн дүнгээр 880 га-д хүрч өнгөрсөн жилээс 4.3 хувиар өслөө.

2020 оны ургацнаас газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 86 аж ахуйн нэгж, иргэн “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”, улсын нөөцөд болон дотоодын гурилын үйлдвэрт 25.0 мянган тн улаанбуудай тушаасан материалыг Хүнсний улаанбуудайн урамшуулах олгох журмын дагуу хүлээн авч, Хөдөө аж ахуйн дэмжих санд хүргүүллээ.

5.4. Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд: Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн дэмжих чиглэлээр Засаг даргын нөөц сангийн эх үүсвэрийг 600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, тусгай сангуудаас нийт 463 үйлдвэрлэлийн төсөлд 3848.8 сая төгрөгийн зээл олгож, нийт олгосон зээлийн 58.4 хувь буюу 2249.0 сая төгрөгийн зээлийг боловсруулах үйлдвэрлэлд олголоо.

Улмаар тусгай сангуудын 30 хүртэлх хувийг эрсдлийг бууруулахад зарцуулах болон Аймаг хөгжүүлэх сан болон Сум хөгжүүлэх сангийн зээлийн төлбөрийг түр хойшлуулах шийдвэр гаргалаа.

“Мах сүүний анхдугаар аян”, “Хоршоо хөгжүүлэх аймгийн хөтөлбөр” хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэгдлээ.

2020-2021 онд хүнсэнд хэрэглэх болон зах зээлд нийлүүлэхээр 58.3 мян.тн мах бэлтгэж, 3 махны үйлдвэр, 4 мал төхөөрөх цехүүд 13600 тн мах үйлдвэрийн аргаар бэлтгэн, зах зээлд нийлүүллээ.

6. Стандарт, хэмжил зүйн чиглэлээр:

6.1. Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт ажлын хүрээнд: Зуунмод, Сэргэлэн сумын 7 худалдаа, үйлчилгээ, 1 бүтээгдэхүүн үйлчилгээнд стандартын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгох, сунгах ажлыг зохион байгууллаа. 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 271 үйлчилгээ, 5 бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олголоо. Стандартын мэдээлэл, лавлагаа үйлчилгээг 11 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүллээ. Баян, Сэргэлэн, Зуунмод суманд үйл ажиллагаа явуулдаг Шунхлай трейд , Газ Ойл Нефьт, Магнай трейд зэрэг компаний харьяа 10 шатахуун түгээх станцын 19 ш хэмжих хэрэгсэл баталгаажууллаа.

7. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

7.1. Орчны бохирдолын талаар: Аймгийн хэмжээнд нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний замын цас мөсийг 12 сард 146 төрийн байгууллага, аж ахуйн нэгж иргэд, 559 хүн хамрагдан нийт 136,8 м^3 цасыг цэвэрлэлээ.

7.2 Усыг хамгаалах, зүй зохистой ашиглах ажлын хүрээнд: "Ус" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2-р үе шатны /2017-2021/ төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг 2020.12.21-нд Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүллээ. ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнтэй хамтарч хийсэн "Рашаан, рашаан төст булгийн судалгааны ажил"-ын үр дүнг 12 сарын 11-нд Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, ажлын гүйцэтгэгчид санхүүжилтийг олголоо. Судалгаанд Төв аймгийн баруун болон хойд 7 сумын 23 рашаан, рашаан төст булаг хамрагдлаа.

7 .3. Биологийн төрөл зүйлийн ажлын хүрээнд: Ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааг хийж дууссан ба аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 1 сарын хурлаар оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Ерөнхий ан агнуурын 2021-2025 оны менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг “Монгол орны хөхтөн судлалын нийгэмлэг” ТББайгууллага хамтран хийж байна.

8. Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр

8.1. Урьдчилан мэдээлэх: Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7, 10 хоног тутмын цаг агаарын тойм мэдээг тус тус гаргаж, и-мэйл-ээр дамжуулж, www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд и-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, төв талбай болон байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна. 12 дугаар сарын 21-22-нд Төв аймгийн ихэнх нутгаар цас орж, цасан шуурга шуурахыг анхааруулах мэдээг 12-48 цагийн өмнө 2 удаа www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д, Дотоод удирдлагын системийн олон нийтийн цэсэнд байршуулж үйлчиллээ.

8.2. Байгаль орчны шинжилгээний лаборатори: Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар нийт 42 удаа ажиглалт хийхэд хүхэрлэг хийн дундаж агууламж 0.035 мг/м^3 азотын давхар ислийн дундаж агууламж 0.017 мг/м^3 үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүхэрлэг хийн дундаж агууламж 0.020 мг/м^3-ээр, азотын давхар ислийн дундаж агууламж 0.007. мг/м^3-ээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

8.3. Гадаргын усны чанар: Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 12 дугаар сард Туул-Лүн голын хяналт шинжилгээний цэгээс усны сорьц авч химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойллоо. Шинжилгээний дүнгээс үзэхэд голын усны эрдэсжилтүүд 201.4 мг/мл байсан, голын ус органик бодисын болон эрдэс азотын бохирдолгүй цэвэр байна.

8.4. Ус судлалын салбар: Төв аймгийн нутаг дэвсгэрт 7 ус судлалын харуул ажиллаж, 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар Хэрлэн голын усны түвшин Хэрлэн-Хонгон харуулд-155 см, Хэрлэн-Мөнгөнморьт-112 см, Туул гол Туул-Алтанбулаг харуулд -543 см, Туул-Лүн

харуулд-144 см, Туул-Заамар харуулд-168 см. Сөгнөгөр голын усны түвшин Сөгнөгөр-Сөгнөгөр харуулд 160 см, Шивэрт гол Шивэрт-Борнуур харуулд 106 см тус тус байна. Өмнөх оны мөн үетэй усны түвшинг харьцуулахад Туул-гол 12-17 см-ээр их, Хэрлэн гол Хэрлэн-Мөнгөнморьт харуулд 7-18 см-ээр бага, Сөгнөгөр гол Сөгнөгөр-Сөгнөгөр харуулд 29 см-ээр тус тус бага байна. Хэрлэн, Туул, Сөгнөгөр голууд нь 31-66 см-ийн зузаан мөсөн бүрхүүл үүссэн ба мөсөн дээгүүр тээвэр хийхэд цөмрөх аюултай тул мөсөн дээгүүр зорчихгүй байхыг анхааруулж www.tuv.tsag-agaar.gov.mn цахим хуудсаар мэдээллээ.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр Мерит төсөлтэй хамтран "Оролцоонд суурилсан Жендэрийн аудит"-ын арга хэмжээг аймгийн Засаг даргын захирамжаар 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулж бүтэн 7 сарын хугацаанд зохион байгууллаа.

Энэхүү ажлын хүрээнд АЗДТГ-ын ажилтан, албан хаагчдын дунд жендэрийн чиглэлээр ойлголт хандлагыг тодорхойлох асуулгыг аудитын эхэнд болон төгсгөлд цахим болон цаасан сууриар авч нийт 72 ажилтан, албан хаагчдыг хамруулж, аудитын дүгнэлтийг эцэслэн боловсруулж, тайлагнах, англи хэлээр орчуулах ажил хийгдэж байна.

Охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилго бүхий "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян" Монгол Улс 23 дах жилдээ "Өрх гэр, ажлын байр олон нийтийн газарт " Яг одоо хүчирхийллийг цэглэе!" уриан дор аянд нэгдлээ. Энэ хүрээнд Төв аймаг нэгдэж 11 дүгээр сарын 25-ны өдөр орон нутгийн телевиз болох Төв телевизийн цахим шууд нэвтрүүлэгт Аймгийн Засаг дарга Д. Мөнхбаатар оролцон 27 сумын удирдлагууд болон ард иргэддээ хандан уриалга гарган ажилласнаар Ковид цар тахал нүүрлэсэн, хөл хорионы энэ цаг үед 2 төрлийн постерийг шинээр бэлтгэн хүргэж, 3600 хандалт, 10 төрлийн постерийг байгууллагын пейж хуудсаар дамжуулан түгээж, 42689 хандалт авч ажилласан. Мөн агентлаг, сумдын хэмжээнд 55 байгууллагын 3962 иргэн, албан хаагч аянд нэгдэж, сургалт мэдээлэл, тэмцээн уралдаанд хамрагдаж, 389 төрлийн постер, видеог пейж хуудсаар түгээн, 21 640 хандалт авч, хүчирхийллийг хамтдаа цэглэх зорилгыг хангаж, цахим мэдээлэл түгээж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар Аймгийн Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр, түүнийг хэрэгжүүлэх 2019-2020 оны төлөвлөгөөний 5 зорилт 47 хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн танилцуулж 84 %-ийн гүйцэтгэлтэйгээр дүгнэгдсэн нь өмнөх төлөвлөгөөний хэрэгжилтээс 16.7% -иар ахисан үзүүлэлттэй байлаа.

4.Төрийн мэдээллийн цахим санд Нийгмийн салбарын холбогдох жилийн эцсийн мэдээ тайланг бүрэн оруулж баталгаажуулаа.

5. БШУЯ, СЯ, ЭМЯ, ХНХЯ-ын төсвийн ерөнхийлөн захирагч болон Төв аймгийн Засаг даргын хооронд 2020 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг дурьдсан хугацаанд гаргаж хүргүүллээ.

Аймгийн боловсрол соёл, урлагийн газар:

Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдалд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Төрийн аудитын газарт хүргүүллээ.

"Үр дүнд суурилсан үнэлгээний шинэчлэл" цахим сургалтад сургуулийн удирдлага, багш нарыг хамруулаа.

"Боловсролын тухай хуулийн хэлэлцүүлэг", "Сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын тухай хуулийн хэлэлцүүлэг"-үүдийг 3 үе шаттай зохион байгуулах, сургууль, цэцэрлэгүүдийнхээ саналыг татан авч нэгтгэх, сургууль цэцэрлэгүүдээс долоо хоногт 3 удаа 6 төрлийн мэдээг авч нэгтгэн аймгийн Онцгой комисс болон БШУЯ-д хүргүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Албан бус насан турш боловсролын төв:

Насан туршийн боловсролын үндэсний төвөөс Насан туршийн боловсролын багш нарыг чадавхжуулах 2 шатны онлайн сургалтыг 12 дугуур сарын 01-07 хооронд зохион байгууллаа.

Соёлын салбарын хүрээнд:

Аймгийн МТТ:

1. 2020 оны 12 дугаар сарын 01-ээс 20-ны хооронд Соёлын яамнаас хэрэгжүүлж буй "Цахим орчинд соёл түгээе-би хариуцлагатай иргэн" аяны хүрээнд Монгол туургатан театрын уран бүтээлчид 11 удаагийн лайв тоглолтыг зохион байгууллаа.

2. 2020 оны шинэ жилийн “Мөнгөн үдэш” цахим арга хэмжээг 12 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж аймгийн “Төв” телевиз болон “Өлзий” телевизээр иргэдэд шууд дамжуулан хүргэлээ.

Нийтийн номын сан:

1.12-р сард төсвийн 968.600 төгрөгийн 64 ширхэг ном авч фонд баяжилтаа нэмэгдүүлж уншигчийн хүртээл болгож байна.

2.Тухайн сард тогтмол хэвлэлийн хадгалалт хамгаалалтад хяналт тавьж “ӨДРИЙН СОНИН”-г 6 багц , “ЗУУНЫ МЭДЭЭ”-г 2 багц, “ҮНДЭСНИЙ ШУУДАН”-г 2 багц, “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ” сэтгүүлийг 2 багц болгон сар, улирлаар нь багцалж нийт 12 нэгж болгож иргэд уншигчдад түргэн шуурхай мэдээлэл авах нөхцөл боломжийг бүрдүүллээ.

Аймгийн Музей:

1. Соёлын өвийг иргэдэд сурталчлах, танин мэдэхүйг дээшлүүлэх зорилгоор Төв аймаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрын мэдээллийг багтаасан календарийг 100 ширхэг, Музейн үзмэрийн гэрэл зураг, Түүх соёлын үл хөдлөх дурсгалын гэрэл зураг, биет бус өвийн өвлөн уламжлагчийн гэрэл зургаар нийт 850 ширхэг ил захидал буюу 150 сэт ил захидлыг тус тус хэвлүүллээ.

2. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу Соёлын биет бус өвийн шилдэг өвлөн уламжлагчийн шагналд Алтанбулаг сумын Эсгий урлалын өвлөн уламжлагч Долгорын Цэндсүрэнг нэр дэвшүүлсэн материалыг Соёлын өвийн төвд хүргүүллээ.

Аймгийн биеийн тамир спортын газар:

1.2020 оны 12-р сард 3 удаагийн цахим сургалтад 81 багш, албан хаагчдыг хамруулж цахим уралдаан тэмцээнийг 4 төрлөөр зохион явуулж 240 гаруй сурагчийг хамруулж, 2020 оны амжилтаараа шилдгээр шалгарсан 59 хүүхдийг шагнаж урамшуулахад 10.1 сая төгрөг зарцууллаа.

2. Аймгийн Биеийн тамирын багш нарын цахим сургалтыг 2020.12.14-нд зохион явуулж 27 сумын 49 багш оролцлоо.

3. Спорт холбоодын форум зөвлөгөөнийг 2020.12.16-нд цахимаар зохион байгуулж, 20 спорт холбоодын 24 хүн хамрагдсан.ЗГ-ын тохируулагч БТС-ын Улсын Хорооноос аймгуудын БТС-ын газрын дарга, архив бичиг хэрэг, хүний нөөц, ахлахууд, мэдээлэл технологи, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хариуцсан мэргэжилтнүүдэд цахим сургалтуулыг зохион байгуулж 8 мэргэжилтэн хамрагдлаа.

4. ЕБС-ийн сурагчдын дунд цахим уралдааныг Миний дуртай дугуйн спорт, Миний дуртай шагайн харваа, Өөрийгөө хөгжүүлье 5-н чадавхын уралдаан, Чөлөөт бөхийн дасгалыг хэн сайн хийх вэ уралдаануудыг зохион явуулж 3 аймгийн 240 гаруй сурагчид хамрагдлаа.

5.Монгол улсын Үнэн хүчит Заан Б.Батмөнх БТС-ын Газартаа цар тахлаас сэргийлэх, ажилтан албан хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор маск ариутгагч зэргийг хандив болгон өглөө.

6. Цар тахалтай үед ажилчдын 70 %-нь гэрээсээ ажлаа хийж байгаа үед гэр бүл үр хүүхдэдээ зарцуулах цагийг нэмэгдүүлснээр “Халамж хайраа гэр бүлдээ уралдаан”-ыг нийт ажилчдын дунд зарлан тэрүүн байр эзэлсэн албан хаагчдыг шагнаж урамшууллаа.

7. 2020 оны шилдэг тамирчин, дасгалжуулагч, сум, сургууль, спортын холбоо, биеийн тамирын багш нараа тодруулан шалгаруулж Шилдгийн шилдэг тамирчнаар Эрдэнэ сумын сурагч дугуй, тэшүүрийн өсвөрийн шигшээ багийн тамирчин Г.Номин-Эрдэнэ, шилдэг бага сургууль Ш.Туяагэрэл захиралтай ХЦБага сургууль, шилдэг ахлах сургууль А.Эрдэнэбат захиралтай Батсүмбэр сум, шилдэг сумаар Д.Ганболд даргатай Батсүмбэр сум, шилдэг биеийн тамирын багшаар Лүн сумын багш Ж.Уранболд, шилдэг холбоогоор С.Гантөр тэргүүнтэй Хөл бөмбөгийн холбоод шалгарлаа.

Аймгийн эрүүл мэндийн газар:

Аймгийн хэмжээнд 2020 оны 11 сарын байдлаар 980 эх төрж өнгөрсөн мөн үеийнхээс 24 тохиолдлоор буурсан ба 983 нярай бүртгэгдсэн байна. Нийт 306629 иргэнд үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 137138, амбулаторийн үзлэг 122157, идэвхтэй хяналтын 23616 үзлэг хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 16860 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, стационарт 12469 хүн эмчлэгдэн нийт 91713 ор хоног ашигласан. Дундаж ор хоног 7,4 байна.

Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийг цахимаар магадлан итгэмжлэлд хамруулж, хобогдох материал, хурлын тэмдэглэлийг ЭМХТөвд хүргүүллээ.

2020-2021 оны хичээлийн жилийн үндсэн мэргэшлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр суралцах 8 эмчийн төрийн сангийн гэрээг ЭМХТ-д хүргүүллээ.

Ковид-19-ын үед ажиллах тархвар судлагч, ариутгагч, лабораторийн техникч нарыг дадлагажуулах 103 эмнэлгийн мэргэжилтний нэмэлт элсэлтийн судалгааг гарган ЭМХТ-д хүргүүллээ.

2021 онд мэргэжлийн зэргийн хугацаа дуусах, шатлал ахиулах, шинээр зэрэг горилогч нарын судалгаа гаргаж салбар нийгэмлэг, ЭМХТ-д хүргүүлсэн. Эрүүл мэндийн салбарын нийт албан хаагчдын

мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн судалгаа гаргасан. 2020 онд шалгалтад орох 17 эмч, эмнэлгийн мэргэжилтнээс 13 албан хаагч орж 10 тэнцлээ.

Ковидын үед ажиллаж байгаа хүний нөөцийн судалгаа гаргаж ЭМХТ-д өдөр бүр өгч байна. Эрүүл мэндийн салбарт тэтгэвэрт гарсан 59 албан хаагч ажиллаж байна.

2021 оны эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийн захиалгыг нэгтгэн ОНӨГ-т хүргүүлэн, тендер зарлагдсан. ЭМЯ-аас Ковидын 10000 ширхэг түргэвчилсэн оношлуур авч 2200 ширхгийг 28 эрүүл мэндийн байгууллагад хуваарилсан. ЭМГ-ийн нөөцөд 7800 оношлуур байна.

Коронавирусын халдварын 4 сэжигтэй тохиолдлын голомтод ажиллан хариу арга хэмжээг гүйцэтгэн ажилласан.

ХӨСҮТ-д PCR шинжилгээнд нийт анхан сорьц 96, давтан 18 сорьцыг хүргүүлсэн Үүнээс 12 сард анхан 42 давтан 4 сорьц байна. Улаанбаатар хотоос ирсэн 5 иргэнээс PCR шинжилгээний тандалтын сорьц авч ажилласан. Халдварт өвчин судлалын үндэсний төвд коронавирусын халдвар авч батлагдсан тохиолдол хэвтэн эмчлүүлж байгаад гарсан иргэн Заамар сумын 4-р багийн нутаг дэвсгэрт өөрийн гэртээ 2020.12.18-ны өдөр ирсэн. ХӨСҮТ-өөс ирүүлсэн зөвлөмжийн дагуу гэр бүлийн 2 хүнээс PCR шинжилгээний анхан болон давтан сорьцыг авч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд COVID-ийн түргэвчилсэн оношлуураар 2795 удаагийн шинжилгээг гүйцэтгэсэн. Коронавирусын халдварын сэжигтэй болон дам хавьтал, орон нутагт шилжилт хөдөлгөөн хийж ирсэн 214 иргэнийг тархвар судлалын заалтаар гэрийн ажиглалтад авч ажилласан. Өнөөдрийн байдлаар Батсүмбэр 4, Баян-Өнжүүл суманд 4, Заамар суманд 3 иргэнд харъяа эрүүл мэндийн төвийн хяналтад байна.

Коронавирусын халдварын голомт бүхий бүс нутгаас шилжилт хөдөлгөөн хийж ирсэн 3733 иргэнийг бүртгэн авч харъяа эрүүл мэндийн байгууллагууд хяналтандаа авч ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар тусгаарлалтаас гарч хугацаа дуусаагүй 558 иргэн байна.

Тусгаарлан ажиглах байраар ажиллаж байсан Баянхангай, Налгар амралтын газруудад байсан иргэд тусгаарлах хугацаа дууссан тул эцсийн халдваргүйжүүлэлтийг 1056 мкв талбайд хийж гүйцэтгэсэн. Коранавирусын халдварын сэжигтэй тохиолдлын голомтод эцсийн халдваргүйжүүлэлтийг 225 мкв талбайд, Улаанбаатар хотоос иргэдийг тээвэрлэн ирсэн автобусанд 51 удаагийн 918 мкв талбайд халдваргүйжүүлэлт хийсэн.

Орчны эрүүл мэндийн лабораторийн химий, нян судлалын шинжилгээнд Төв Чандмань ДЭХГ-ын 15 унд ахуйн усанд шинжилгээг нян судлалын 45, химийн 300 үзүүлэлтээр гүйцэтгэв. Стандартын шаардлага хангаагүй сорьц 1 байна.

Халдварт өвчний 12 тохиолдлын голомтод тархвар зүйн тандалт судалгаа хийж голомтын болон эцсийн халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэлээ.

Эрүүл мэндийн салбарын 2020 оны үйл ажиллагааны тайланг нэгтгэн, холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлж, цахим системд оруулсан.

Сургалт:

Зуунмод сумын 2,3,5-р багуудаар явж зорилтот бүлгийн 50 хүүхдэд амны хаалт зөв зүүх, зөв тайлах аргачлал, гараа тогтмол зөв угаах аргачлал, дараалаар мэдээлэл өгч, хүүхэд бүрт 10ш амны хаалт, бактерийн эсрэг саван, гар халдваргүйжүүлэгч, дархлаа дэмжих үрэл 3ш, гар угаах дараалал, амны хаалт зөв зүүх зөвлөмж бэлтгэн тараасан.

ЭМЯ, Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос зохион байгуулсан “Коронавирусын халдварын тохиолдолд тусламж, үйлчилгээ үзүүлж буй ажиллагсдыг халдвараас сэргийлэхэд анхаарах асуудлууд”, Хамар, залгиураас сорьц авахад анхаарах асуудал”, “Коронавируст халдварын “КОВИД-19” эмчилгээ” Коронавирусын халдварын хариу арга хэмжээ сэдэвт цахим сургалтад 5 мэргэжилтэн хамрагдсан.ЭМЯ, ХӨСҮТ-өөс зохион байгуулагдсан Томуугийн үндэсний зөвлөгөөнд тархвар судлагч нар хамрагдсан.

Коронавируст халдвартай тэмцэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах чиглэлээр бүсчилсэн сургалтыг ОБГ, аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан Ковид- 19 цар тахлын үеийн шинжилгээний сорьц авах , тээвэрлэх эмнэлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэх цахим сургалтанд сумын эрүүл мэндийн төвийн 176 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдлаа.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор Эрүүл мэндийн газрын даргын 4/868 дугаар албан тоотыг 27 сум эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвд хүргүүлэн Хувийн хамгаалах хувцас хэрэгслийн зөв өмсөж тайлах ажлын байрны дадлага сургуулалтыг эрүүл мэндийн төвүүдийн халдварын сэргийлэлт хяналтын багийн гишүүд хариуцан зохион байгуулан 621 эмч, эмнэлгийн ажилчид 16-20 хүртэлх удаагийн давтамжтайгаар гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу “Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах нь” сэдэвт бүсчилсэн ажлын байрны сургалтыг 2020 оны 12

дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвд Өндөрширээт, Заамар, Лүн, Эрдэнэсант, Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвүүд Борнуур сумын Эрүүл мэндийн төвд Борнуур, Жаргалант, Сүмбэр, Батсүмбэр, Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн нийт 80 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд онол, дадлага хосолсон сургалтыг зохион байгууллаа.

Нийгмийн даатгалын хэлтэс:

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурал 4 удаа хуралдаж, 42 цаг нийт 295 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 21 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, 261 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 13 иргэнийг цуцаллаа.

1995-2019 оны шилжилийн үед шимтгэлээ төлж чадаагүй Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчийн иргэдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх тухай хуулийн хүрээнд 12 сард 161 иргэнийг хамруулан шимтгэлийг нөхөн төлүүллээ.

Нийгмийн даатгалын тухай хууль”-д заасан болзол хангаж шинээр тэтгэвэр тогтоолгосон 461, шилжиж ирсэн 35, ажилласан жил нэмүүлэх, тэтгэврээ өөрчлөн тогтоолгосон 121, нийт 617 хувийн хэргийг шалгаснаас 112 хувийн хэрэгт бүрдүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу, шаардлага хангаагүй зөрчил илэрснийг арилгуулан, тэтгэврийг хянаж тэтгэвэр авах эрхийн нөхцлийг хангаж ажиллалаа.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль”-ийг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавьж мэдээллийн баазад оруулсан 214 хувийн хэргий шалгаж, зөвлөмж өгч ажилласан.

Цахим хяналт шалгалтын хүрээнд 451 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн алдаатай мэдээлэл, Ажилгүйдлийн тэтгэмж, Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн эрхийн нөхцөл, олголттой холбоотой 81 даатгуулагчийн мэдээллийг шалгаж, зөрчлийг арилгуулан ажиллалаа.

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 484 дүгээр тогтоолоор баталсан “Зарим иргэний тэтгэврийг нэмэгдүүлэхэд баримтлах журмын дагуу нийт 1493 тэтгэвэр авагчдад 78.2 сая төгрөгийн нэмэгдэлолгоод байна.

Аймгийн хэмжээнд 14947 тэтгэвэр авагчдад 6 тэрбум төгрөгийн тэтгэвэр олголоо.

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөх, Ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай журмын хэрэгжилтийг ханган ажиллаж, 545 ААН-ийн 4000 даатгуулагчдад 2751.1 сая, Ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн үйл ажиллагаа нь доголдсон, орлого нь буурсан 54 ААН-ийн 325 даатгуулагчид 196,0 сая төгрөгийн дэмжлэгийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгоод байна. Сайн дурын даатгалын чөлөөлтөд 5518 сайн дурын даатгуулагч хамрагдаж 1926.0 сая төгрөгийн чөлөөлт эдэлсэн байна.

Аймгийн хэмжээнд 163 даатгуулагч жирэмсэн амаржсаны тэтгэмж 245.1 сая, 128 даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 24.3 сая, 65 даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмж 154.4 сая, ҮОМШӨ 4 даатгуулагчийн 4.7 сая нийт 428,5 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар

Хүүхэд хамгааллын чиглэлээр:

Аймгийн хэмжээнд “Хайраар дүүрэн богц” аяныг өрнүүлэн ажилласнаар нийт 1.099.190 төгрөгийн тусламж бүрдсэнийг Зуунмод сумын 28 өрхөд тусламж болгон түгээж ажилласан.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо ны хоёрдугаар хуралдаанаар Батсүмбэр, Баянчандмань сумдын Хамтарсан багийн мэдээлэл орж, мэдээлэлд үндэслэн Хууль зүйн хорооны даргын албан чиглэлийг сумдын Хамтарсан багт хүргүүлсэн. Аймгийн Прокурорын газар,Шүүхийн тамгын газар, Цагдаагийн газрууд Насанд хүрээгүй хүний гэмт хэргийн мэдээлэл, хүүхдийн асуудлаар гарсан шүүхийн шийдвэрийн талаарх мэдээлэл зэргийг танилцуулсан.

Гэр бүлийн хөгжил, хамгааллынчиглэлээр:

1. Аймгийн Засаг даргын 2018 оны А/263 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, “Хүүхдэд ээлтэй, эцэг эхийн зөвлөл”-д болзлын дагуу 7 байгууллага тайлан ирүүлж дараах байгууллагууд “Хүүхдэд ээлтэй эцэг, эхийн зөвлөл”-өөр шалгарлаа. Үүнд:

Аймгийн эрүүл мэндийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газрууд тус тус шалгарч, Батламж, мөнгөн шагналаар тус тус шагнагдлаа. Урамшуулалд нийт 1.059.000 төгрөг зарцуулагдлаа.

2. Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хөл хорио тогтоосонтой холбоотойгоор Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг цахимаар хүлээн авч, Жаргалант, Зуунмод, Баянчандмань, Лүн сумдын гэр бүлийн хүчирхийллийн 4 хохирогчид эрүүл мэндийн, нийгмийн ажлын болон холбон зуучлах, сэтгэл зүйн үйлчилгээг тус тус үзүүлсэн. Үйлчилгээний зардалд 1.5 сая төгрөг зарцуулсан байна.

Залуучуудын чиглэлээр:

3 алуу гэр бүлд "Гэр бүл төлөвлөлт, хүүхэд хөгжлийн алхмууд" сэдэвт сургалтыг 2020 оны 12 сарын 22-ний өдөр "Хөөрхөн шар шувуу" сургалтын төвийн багш Г.Төмөрзаяатай хамтран зохион байгуулж, нийт 44 албан хаагчид цахим сургалтад хамрагдсан.

Өсвөр үе залуучуудад Амьдрах ухааны модуль сургалт "Нөхөн үржихүй эрүүл мэнд", "Гэр бүл төлөвлөлт", "БЗДХ, Бэлгэвчний хэрэглээ" сургалтуудыг 2020 оны 12 сарын 23-ний өдөр "Хамтдаа төв" ТББ- ийн багш Ш.Галбадрахтай хамтран зохион байгууллаа.

TIKTOK "Зөв харилцаа-Эерэг нийгэм" цахим уралдааныг аймгийн "Төв" телевизтэй хамтран зохион байгуулж, бичлэгийн уралдаанд 15 хүүхдийн 7 бүтээл ирснийг байгууллагын фэйсбүүк болон пэйж хуудсанд байршуулж, хандалтаар байр эзэлүүлсэн. Уралдааны эхний гурван байранд шалгарсан хүүхэд, залуучуудад дурсамж, мөнгөн шагнал, итэвхтэй оролцсон хоёр залууд талархал гардуулж өгсөн. Уралдаанд 300.000 төгрөгийг зарцуулж, цахим сургалт, тэмцээнд нийт 1.000.000 төгрөгийг зарцуулсан.

Цаг үеийн асуудлаар Төв телевизийн live-аар орж, мэдээлэл ярилцлага өгч ажиллалаа.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар:

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ

2020 оны 12-р сарын байдлаар1988 иргэнд 5406,5 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1535 иргэнд 1243,6 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1258 иргэнд 864,5 сая төгрөгийн амжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж, 4071 ахмад настанд 681,9 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж,5412 ахмад настанд 860,2 сая төгрөгийн насны хишиг, 740 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 191,4 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 6845 иргэнд 1540,7 сая төгрөг, жирэмсэн 2035 эхэд 976,8 сая төгрөгийн тэтгэмж, алдар цолтой 61 ахмад настанд 111,6 сая төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 6100 эхэд 3005,9 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 319 эх /эцэг/-т 340,0 сая төгрөг, 2 ихэр хүүхэд төрүүлсэн 18 эхэд 36.0 сая төгрөг, алдарт эхийн 1, 2-р одонтой 9112 эхэд 1189,9 сая төгрөг тус тус олгосон.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн хүрээнд:

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020.11.30-ны өдрийн 7-р тогтоолоор Корона вируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээг баталсан бөгөөд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 2018-2020 онд хамрагдсан иргэдэд нэмэлт санхүүжилт олгож, гэрээг шинэчлэн байгууллаа. Тухайлбал ХХҮГ-ын даргын 2020.12.10-ны өдрийн А/125 дугаарын тушаалаар ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Баяндэлгэр, Баянцогт, Алтанбулаг, Зуунмод, Борнуур сумын 5 иргэнд 8,0 сая төгрөгийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Баян, Зуунмод, Баяндэлгэр сумын 4 иргэнд 7,6 сая төгрөгийн, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний хөтөлбөрийн хүрээнд Зуунмод сумын 2 иргэнд 2,0 сая төгрөгнийт хөтөлбөрүүдийн хүрээнд 11 иргэнд 17,6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгож, бизнесийг нь дэмжин, ажлын байрыг нь хадгаллаа. Хөдөлмр эрхлэлтийг ЭҮЗөвлөлийн тогтоол, ХХҮЕГазраас ирүүлсэн 2020.12.03-ны өдрийн №1/1636 тоот чиглэлийн дагуу ХЭДСангаас санхүүгийн дэмжлэг авч, эргэн төлөлтөө гэрээний үүргийн дагуу бүрэн барагдуулж байгаа иргэдийн бизнесийн хүндрэлтэй байдал, хүсэлтийг харгалзан зээлийн эргэн төлөлтийг 6 сараар буюу 2021.07.01-ний өдрийг хүртэл хойшлуулах шийдвэрийн дагуу 2 хөтөлбөр, 1 төслийн арга хэмжээний нийт 16 иргэний зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулж, гэрээнд өөрчлөлт оруулаа.

Түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийн талаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2019, 2020 онуудад жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан, 3 буюу түүнээс дээш сарын хугацаанд ажлын байр түрээсэлж байгаа 5 сумын 18 иргэнд 2020 оны 11, 12 дугаар сарын нийт 6,1 сая төгрөгийн түрээсийн хөнгөлөлтийг журмын дагуу олгож, бизнесийн үйл ажиллагааг нь дэмжиж ажиллалаа.

Зохион байгуулалтай ажлын байрыг дэмжих арга хэмжээний хүрээнд:

ХХҮГ-ын даргатай байгуулсан гэрээний дагуу сумын Засаг даргын захирамжаар баталгаажсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн Борнуур, Баянчандмань, Эрдэнэ сумын хөдөлмөрийн бүлгүүдийн гишүүдэд 12 дугаар сарын цалин нийт 1,5 сая төгрөгийн санхүүжилт олгож, гэрээний дагуу иргэдийн эрүүл мэндийн даатгалд 0,7 сая шимтгэлийг нийгмийн даатгалын санд төлж барагдуулаа.

Ахмад мэргэжилний зөвлөх үйлчилгээний хүрээнд:

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулахаар Борнуур, Дэлгэрхаан, Баян сумдын Засаг даргаас хөдөлмөр, халамжийн азрын даргатай байгуулсан гэрээний дагуу дээрх сумдаас ирүүлсэн тайлан,

хэрэгжилтийг дүгнэж 6 ахмадад нийт 5,0 сая төрөгийн санхүүжилтийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллалаа.

Гэрээт малчныг дэмжих арга хэмжээний хүрээнд:

Гэрээт малчдын арга хэмжээнд 2019, 2020 онд хамрагдан сумын Засаг дарга болон ХХҮГ-ын даргатай байгуулсан гэрээний дагуу үүргээ амжилттай биелүүлж гэрээт малчдын цалинг тогтмол олгож, нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн төлсөн Заамар сумын малчин ажил олгогч Б.Аюуш, Д.Мөнхбат, М.Содбаяр, Д.Отгонбаатар нарын нийгмийн даатгалтын шимтгэл, гэрээт малчин Б.Баянмөнх, Б.Отгонжаргал, М.Мөнхсайхан, Л.Ганбаатар нарын НДШ, ЭМД-ын шимтгэлийг гэрээнд заасан хэмжээгээр төлж, ХЭД сангаас нийт 1,6 сая төгрөгийн нөхөн олговрыг малчин ажил олгогчид санхүүгийн баримтыг үндэслэн нөхөн олгосон. Засгийн газар, салбарын яамнаас шинэчлэн гаргасан хууль эрх зүйн баримт бичгийн талаар сумын мэргэжилтэн болон малчдад зөвлөмж өгч ажиллалаа.

Хүүхэд хамгаалагч төслийн хүрээнд:

Цагдаагийн байгууллага, ГБХЗХГ, ХХҮГ-ын дарга нарын байгуулсан гэрээний дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Хүүхэд хамгаалагч төсөлд хамрагдсан 3 ахмадад тайлан, цагийн бүртгэлийг үндэслэн нийт 1,9 сая төгрөгийн урамшуулал олголоо.

<u>Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:</u>

Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө 11 сарын байдлаар орон нутаг 5558.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 7106.4 сая төгрөг төвлөрүүлж 127,9 хувьтай, 1548.3 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давуулан биелсэн байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 16133.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 17313.9 сая төгрөг төвлөрүүлж 107.3 хувьтай, 1180,5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 2929.3 сая төгрөгөөр давж, 111.3 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Аргалант, Батсүмбэр, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянхангай, Баянцагаан, Баянцогт, Бүрэн, Дэлгэрхаан, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сүмбэр, Угтаал, Эрдэнэсант, Зуунмод зэрэг 16 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Баянжаргалан, Заамар, Сэргэлэн, Цээл, Эрдэнэ зэрэг 6 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Архуст, Баянчандмань, Борнуур, Жаргалант зэрэг нийт 5 сум байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Сумдад эхний 11 сарын байдлаар нийт 74452,6 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл:

Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 36424,4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

-Ерөнхий боловсролын сургуулиудад 24572.7 сая төгрөг

-Хүүхдийн цэцэрлэгт 11851.7 сая төгрөг тус тус олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас 8332,4 сая төгрөгийг олгосон.Үүнд:

-Сумдын эрүүл мэндийн төвд 7917,4 сая төгрөг

-Өрхийн эмнэлэгт 415,0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 647,1 сая төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 501.8 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 28546,9 сая төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:

-Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 16452.9 мянган төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 12094,0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

Өр, авлагын талаар:

2020 оны 11-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгуулагууд нийт 181530,0 мянган төгрөгийн авлага, 262869.1 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 39551,1 мянган төгрөг буюу 15.1 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг 5587,9 мянган төгрөг буюу 2.1 хувь нь цалингийн өглөг, 4426.7 мянган төгрөг буюу 1.7 хувь нь НДШимтгэлийн өр, 1324.1 мянган төгрөг буюу 0.5 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, 92454.9 мянган төгрөг буюу 35.2 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 119524,4 мянган төгрөг буюу 45,4 хувийг бусад өр эзэлж байна

<u>Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:</u>

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 01 дүгээр тогтоолоор батлууллаа.



2020 оны жилийн эцсийн тайлан мэдээг сумд, агентлаг, байгууллагуудаас 2020 оны 12 дугаар сарын 25-ны дотор дараах тайланг нэгтгэж, агентлаг байгууллагуудын 2020 оны жилийн эцсийн тайлан мэдээнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийлээ.

	Агентлаг, байгууллагын нэр	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Шийдвэрийн хэрэгжилтэд ХШҮ хийсэн дүн	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ
1	2	3	4	5	6
1	Эрүүл мэндийн газар	96%	97.35%	96.43%	97.95%
2	Онцгой байдлын газар	93.79%	98.47%	88.83%	97.80%
3	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	95.2%	96.09%	92.89%	97.64%
5	Аймгийн дундаж үнэлгээ 2020 он	92.99%	89.40%	79.33%	93.21%

Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар 63 захирамж, 379 арга хэмжээтэй хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 98.40 хувьтай аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлаа бүрэн хангасан байна. Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжил тийг 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд өмнөх онууд /2018, 2019/-тай харьцуулахад 2,99-5,98 функтээр өссөн үзүүлэлттэй байна.

Санхүүгийн хяналтын, аудитын алба:

2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийсэн. Үүнд: Сумдаар: сумдын Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 он, Баянчандмань сумын политехникийн коллеж, Эрдэнэ, Зуунмод сумын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв Сүмбэр, Жаргалант, Угтаалцайдам, Цээл, Аргалант, Дэлгэрхаан, Лүн, Баянхангай, Баянжаргалан, Баяндэлгэр, Баян, Сэргэлэн, Баянцогт, Заамар сумын төсөвт байгууллагууд, Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль, Батсүмбэр, Баян-Өнжүүл сумын эрүүл мэндийн төв

Аймгийн төвд: Аймгийн Музей, Боловсрол, соёл урлагын газар, Монгол туургатан театр, Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн газар, Мал эмнэлгийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Насан туршийн боловсролын төв, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Биеийн тамир спортын газар, Газрын харилцаа, барилго хот байгуулалтын газар, Ус цаг уур, орчны шинжилгээний газар, Зуунмод сумын 4 дүгээр сургууль, 5 дугаар сургууль, Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль, Ирээдүй, Бүжинхэн, Бумбардай, Унагалдайн андууд цэцэрлэгүүд, Баруун зуунмод өрхийн эрүүл мэндийн төв, Зуунмод сумын ИТХ, ЗДТГ, Онцгой байдлын газрын 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж нийт 1997408.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс 265904.4 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт, 1731503.5 мянган төрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага тогтоов. Улсын байцаагчийн актаас 213627.0 мянган төгрөгийг барагдуулсан байна. актын барагдуулалт 80,3 хувьтай байна. Өмнөх оны актын үлдэгдэл 106775,2 мянган төгрөгөөс 43259.2 мянган төгрөг төлөгдсөн байна. Өмнөх оны актын төлөгдөөгүй үлдэгдлийн судалгааг гаргаж Төв аймгийн прокрорын газарт шилжүүлсэн болно.

<u>Найм. Цэргийн штабын хүрээнд:</u>

1. Цэргийн штабын 2020 оны жилийн эцсийн нэгдсэн тайланг БХЯ-ны СБТГ-т 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлсэн.

2. Цэргийн штабын 2020 оны дайчилгааны нууц баримт бичгийн жилийн эцсийн нууцын тооллогын мэдээг 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдөр БХЯ-ны СБТГ-т хүргүүлсэн.

3. Батлан хамгаалахын сайд, төв аймгийн засаг даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилт тайланг БХЯ-ны БТСГ-т хүргүүлэн ажилласан.

4. Цэргийн штабын 2020 онд зохион байгуулсан сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг БХЯ-ны БТСГ-т хүргүүлэн ажилласан.

5. 2021 оны цэргийн тоо бүртгэл явуулах аймгийн Засаг даргын захирамж гарган батлуулж, 2021 оны 01 сарын 04-нөөс сумдад, 01 сарын 25-наас 02 дугаар сарын 04-ний өдөрүүдэд цэргийн штабт зохион байгуулах талаар ажлын төлөвлөгөөг гарган 27 сумдад хүргүүлж үүрэг чиглэл өгч ажиллаа.

6. Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас дайчилгааны бэлтгэл нөөцийн бэлтгэл офицер 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний 2021 онд явуулах сургалтын саналыг БХЯ-ны БТСГ-т хүргүүлэн ажилласан.

7. Аймгийн Засаг даргын 2020 оны А/590 дүгээр захирамжаар 2020 оны 2 дугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан Зэвсэгт хүчин болон хилийн цэрэгт алба хааж байгаа 8 алба хаагчийн ар гэрт хүнсний болон түлээ нүүрсний буцалтгүй тусламж үзүүллээ.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР